



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай-6,
Утас: 26-30-83, Факс: 26-12-73
E-mail: Office@president.mn

2018. 12. 28 № ТГ/1078
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД ТАНАА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын нэг жилийн үйл ажиллагааны танилцуулгыг хүргүүлж байна.

Хавсралт 7.1 хуудастай.

ДАРГА  З.ЭНХБОЛД

0000000716

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

Гарчиг

**НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, УЛС ОРНЫ УДИРДЛАГЫН ТАЛААРХ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД**

1.1.	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон бусад хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хуралтай харилцаж ажилласан талаар:	1
1.2.	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Засгийн газартай харилцаж ажилласан талаар:	17
1.3.	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Шүүх эрх мэдлийн байгууллагатай харилцаж ажилласан талаар:	19
1.4.	Монголын ард түмний эв нэгдэл, улс орны эдийн засаг, улс төрийн тогтвортой байдлыг хангах, шаардлагатай гэж үзвэл бусад асуудлаар Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргах эрхийн хүрээнд:	20

**ХОЁР. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, УЛСЫГ БАТЛАН
ХАМГААЛАХ ТАЛААРХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД**

2.1.	Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүний хувьд:	22
2.2.	Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд:	24

**ГУРАВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД**

3.1.	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж ажилласан талаар:	26
3.2.	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль,	37

	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах эрхийн хүрээнд:	
3.3.	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах бүрэн эрхийн хүрээнд:	38

ДӨРӨВ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН БУСАД АСУУДЛААР

4.1.	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилласан талаар:	40
4.2.	Монгол Улсын Ерөнхийлөгчид Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиас гадна бусад хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилласан талаар:	42

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОДЛОГО, ҮЙЛ ЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

1.	Эв нэгдлийг эрхэмлэж, үндэсний эрх ашгаа дээдэлсэн Эх оронч Ерөнхийлөгч байна.	52
2.	Эрх чөлөө, шударга ёсыг сахин хамгаалж, иргэнээ дээдэлсэн Эх оронч Ерөнхийлөгч байна.	53
3.	Эдийн засгаа сэргээж, аж үйлдвэрийг хөгжүүлсэн эх оронч Ерөнхийлөгч байна.	63
4.	Экологийн тэнцвэрийг хангаж, газар нутгаа хамгаалсан эх оронч ерөнхийлөгч байна.	65
5.	Экспортын шинэ эринийг эхлүүлсэн, эрх тэгш гадаад харилцааг хөгжүүлэгч Ерөнхийлөгч байна.	67

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын
газрын 2018 оны 12 дугаар сарын 28-ны
өдрийн ТТ/1078 дугаар албан бичгийн хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

(2017.07.10-2018.07.10)

Улаанбаатар хот

Төрийн ордон

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын нэг жилийн үйл ажиллагааны талаар Улсын Их Хуралд танилцуулж байна.

**НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, УЛС ОРНЫ УДИРДЛАГЫН ТАЛААРХ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД**

Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн сахиж, хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудтай харилцан ажиллалаа.

1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон бусад хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хуралтай харилцаж ажилласан талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай харилцаж ажиллах бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд 8 удаа оролцож, Улсын Их Хурлын баталсан 4 тогтоолд хориг тавьж, хууль, шийдвэрийн 3 төсөл санаачлан өргөн барьж, 6 албан тушаалтныг томилох асуудлаар Улсын Их Хуралтай зөвшилцжээ. Үүнд:

1.1.1. Улс орны чанартай хойшлуулшгүй чухал асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулган хуралдуулахыг санаачлах бүрэн эрхийн хүрээнд:

Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулснаас хойш найм хоногийн дараа буюу 2017 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч

Х.Баттулга УИХ-ын дарга М.Энхболдод “Ээлжит бус чуулган яаралтай хуралдуулах тухай” Е/04 тоот албан бичиг илгээсэн. Уг албан бичигт намрын ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах, нийслэлд гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний тархалтыг яаралтай зогсоох, 2018 оны улсын төсвийг хэлэлцэж эхлэх шаардлагатай байгаа нэн хариуцлагатай цаг үед Монгол Улс үүрэг гүйцэтгэгч Засгийн газартай байгаа нь төрийн ажил цалгардах, нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавартай учраас ээлжит бус чуулганыг нэн даруй хуралдуулж, шинэ Ерөнхий сайдыг томилон Засгийн газрыг эмхлэн байгуулах шаардлагын дагуу Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг нэн даруй 2017 оны 9 дүгээр сарын 18-наас 22-ны өдрүүдэд хуралдуулах саналыг хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дээрх албан бичгийн дагуу Улсын Их Хурлын ээлжит бус чуулган зарлагдаагүй бөгөөд ээлжит чуулганыг хуульд заасан хугацаанд буюу 10 дугаар сарын 02-ны өдөр нээсэн болно.

1.1.2. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бүрэн эрхийн хүрээнд:

Улсын Их Хурлын нэр бүхий 30 гишүүнээс гаргасан Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэн шийдвэрлэхээр УИХ-ын ээлжит бус чуулганыг 2017 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр зарлан хуралдуулж, 2017 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд Жаргалтулгын Эрдэнэбатыг огцруулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр УИХ-ын дарга М.Энхболдод УИХ-ын ээлжит бус чуулганыг яаралтай хуралдуулж, шинэ Ерөнхий сайдыг томилж, Засгийн газрыг эмхлэн байгуулах шаардлагатай байгаа талаар Е/04 тоот албан бичиг илгээсэн. Монгол Ардын Намын Есдүгээр бага хурлаар Монгол Улсын Ерөнхий сайдад Ухнаагийн Хүрэлсүхийг нэрийг дэвшүүлэхээр шийдвэрлэснийг Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дарга М.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан бүрэн эрхийнхээ дагуу У.Хүрэлсүхийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг тухайн өдөр Е/06 тоот албан бичгээр Улсын Их Хуралд хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд 2017 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн УИХ-ын Байнгын хорооны хуралдаанд, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ын чуулганы 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг томилох асуудлыг танилцуулсан.

У.Хүрэлсүхийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж, 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 56 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг томилсон.

1.1.3. Улсын Их Хурлын чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, төрийн бодлогын аливаа асуудлаар Улсын Их Хуралд саналаа оруулах бүрэн эрхийн хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд дараах асуудлуудыг хөндөн, 8 удаа оролцсон. Үүнд:

Огноо	Асуудал	Үйл ажиллагаа
2017/10/04	Ерөнхий сайдыг томилох санал	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Ерөнхий сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг томилох тухай асуудлаар УИХ-ын чуулганы 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанд танилцуулга хийв.
2017/11/09	Хуульд тавьсан хориг	Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль тус бүрд бүхэлд нь тавьсан хоригийг хэлэлцэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга чуулганы нэгдсэн хуралдаанд биечлэн оролцож, гишүүдэд хандан үг хэлж, байр сууриа илэрхийлэв.
2017/12/15	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал болон бусад	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ын чуулганы хаалттай хуралдаанд оролцож үг хэлсэн. Хаалттай хуралдаанаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал болон бусад асуудлыг хэлэлцэв.
2017/12/28	Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жилийн ой	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож, монголчууд Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жилийн ойд зориулан үг хэлэв.
2018/01/05	Агаарын бохирдолтой “Онц байдал” зарлан тэмцэх	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга агаарын бохирдолтой “Онц байдал” зарлан тэмцэх асуудлаар 2017 оны 12 дугаар сарын 28-нд УИХ-ын даргад албан бичгээр санал хүргүүлсэн. УИХ-ын чуулганы 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч чуулганы хуралдаанд оролцож, үг хэлэв.
2018/02/09	Иргэдээс дэвшүүлсэн	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ын 2017 оны намрын чуулганы хаалтын хуралдаанд

	санал, санаачилга, хүсэлт, гомдол шаардлагыг УИХ үйл ажиллагаандаа тусгаж ажиллах талаар	оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувиар ард иргэдийнхээ санал бодлыг сонсох зорилгоор нийслэлийн 7 дүүрэг болон 7 аймгийн иргэдтэй уулзахад ард иргэдээс дэвшүүлсэн санал, санаачилга, хүсэлт, гомдол, шаардлагыг УИХ ойрын болоод хэтийн бодлого, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах талаар чиглэл өгч, үг хэлэв.
2018/04/05	Иргэдээс дэвшүүлсэн санал, санаачилга, хүсэлт, гомдол шаардлагыг УИХ үйл ажиллагаандаа тусгаж ажиллах талаар	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ын 2018 оны хаврын чуулганы нээлтэд оролцон, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувиар ард иргэдийнхээ санал бодлыг сонсох уулзалтаар иргэдээс дэвшүүлсэн санал санаачилга, хүсэлт, гомдол, шаардлагыг УИХ-д танилцуулж, Үндэсний тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх, тэтгэврийн хэмжээг үе шатлалтайгаар нэмэгдүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр, цэцэрлэг, сургуулийн асуудал, оффшор дансанд хөрөнгөө нуусан улстөрчдийн асуудлыг шийдвэрлэх, "Хүүхдийн мөнгө"-ийг ялгаварлал, алагчлалгүйгээр хүүхэд бүрд олгох, бага насны хүүхдийг хүчирхийлсэн тохиолдолд цаазаар авах ял оноодог байх талаар болон Төрийн ба орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх талаар үг хэлэв.
2018/06/28	Хүүхэд хамгааллын асуудлаар	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож, хүүхэд хамгааллын асуудлаар яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх талаар үг хэлж, төрийн зарим байгууллагуудад хугацаатай албан даалгаврыг өгөв.

1.1.4. Хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хуулийн болон түүнтэй холбогдох шийдвэрийн төслийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх бүрэн эрхийн хүрээнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2018 оны 6 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг УИХ-ын чуулганы 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Энэ дагуу Хууль зүйн байнгын хороо 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, хэлэлцүүлгийн явцад гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэн дэмжсэнээр Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүд батлагдсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх”, “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 02, 2015 оны 01, 2016 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн гэж үзэн, дээрх заалтуудыг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгохоор шийдвэрлэсэн юм.

Шүүх байгуулах тухай хуулийн дээрх заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэхээр, Шүүхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл Засгийн газартай зөвшилцөн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар Багахангай дүүрэгт Иргэний хэргийн анхан шатны шүүх, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Налайх дүүрэгт Иргэний хэргийн анхан шатны шүүх, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийг тус тус шинээр болон өөрчлөн байгуулсан болно.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын хүүхэд бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу “Хүүхдийн мөнгө” олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2018 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн Е/04 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2009 онд батлагдсан Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу тухайн оноос хүүхдийн мөнгийг ямар нэг ялгаваргүйгээр олгож ирсэн боловч уг хуулийг Улсын Их Хурал 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгож, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийгмийн халамжийн тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүүхдийн мөнгө олгох арга хэмжээг нийгмийн халамжийн нэг төрөл болгон, хүүхдийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох болсон. Түүнчлэн Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар баталсан “Хүүхдийн мөнгө олгох журам”-д өмнө нь хүүхдийн мөнгийг “Хүний хөгжил сан”-гаас санхүүжүүлдэг байсныг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэхээр зохицуулж, хүүхдийн мөнгийг Өрхийн мэдээллийн нэгдсэн сан (ӨМНС)-гийн амьжиргааны түвшний 502,567 босго онооноос дээш өрхийн хүүхдэд олгохооргүй болсон юм.

Монгол Улсын үе үеийн Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд бүрд хүртээмжтэй болгох, ялангуяа хүүхэд бүр ижил тэгш орчинд өсөж хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэх талаар анхаарал тавин ажиллаж, шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн бөгөөд эдгээр арга хэмжээний нэг нь хүүхэд, эцэг эхчүүдийн дэмжлэгийг хүлээсэн, эдийн засгийн өсөлт, хямралын аль ч үед хэрэгцээтэй гэдэг нь бодит амьдрал дээр нотлогдож, олон улсад сайн жишээгээр нэрлэгдсэн Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу хүүхэд бүрд олгож байсан “Хүүхдийн мөнгө”-ний бодлого юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч энэхүү хүүхдийн мөнгөний бодлогыг улс орны хойч ирээдүй болсон хүүхдүүдээ ямар нэгэн байдлаар алагчлан ялгаварлахгүйгээр хуульд нийцүүлэн үргэлжлүүлэх бодлого баримталж, тогтоолын төсөл санаачилсан.

Монгол Улсын нийт хүүхдийг өмч хөрөнгө, өрхийн мэдээллийн судалгааг үндэслэн эд хөрөнгийн байдал, нийгмийн гарлаар нь ялгаварлан хүүхдийн мөнгийг олгох, олгохгүй гэж ангилан хувааж буй нөхцөл байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэснийг, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, НҮБ-ын “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн шийдвэр болсон.

Монгол Улсын хүүхэд бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу “Хүүхдийн мөнгө” олгох тухай тогтоолын төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй 0-18 хүртэлх насны Монгол Улсын иргэн бүрд 2018 онд сар бүр 20 000 /хорин мянган/ төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж /хүүхдийн мөнгө/ олгохоор,
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохдоо өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгаанд хамрагдаж, хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан нийт өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд олгохоор,
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохтой холбогдуулан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх, цаашид хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхэд бүрд тогтмол олгохоор жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгахаар тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” болон Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хүүхэд бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмж буюу “Хүүхдийн мөнгө” олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын нэгтгэсэн төслүүдийг УИХ-ын чуулганы 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 80 хувьд хамрагдах хүүхэд бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг сар бүр олгохоор шийдвэрлэж, “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 40 дүгээр тогтоолыг баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч хүүхдийн мөнгийг хүүхэд бүрд олгохын тулд төрийн байгууллагуудын үрэлгэн зардлыг танах, дэд сайд, орлогч дарга гэх мэт эрхлэх асуудал нь тодорхойгүй, чиг үүрэг нь давхардмал албан тушаалуудыг цомхотгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн боловч Улсын Их Хурал дэмжээгүй болно.

3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг УИХ-ын чуулганы 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, УИХ-ын гишүүдийн олонх энэхүү хуулийн төслийг дэмжээгүй учир хууль санаачлагчид нь буцаах шийдвэр гаргасан.

Монгол Улсын байгалийн баялгийг олборлон ихээхэн хэмжээний гадаад валютын орлого олж буй гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд борлуулалтын орлогоо Монгол дахь банк, санхүүгийн байгууллагаар дамжуулдаггүй гаж тогтолцоо амь бөхтэй оршиж байна. Монгол Улсын Их Хурал 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр тогтоолдоо “гадаадын хөрөнгө оруулалттай томоохон төслүүдийн борлуулалтын орлогыг Монгол дахь банкны дансаар дамжуулдаг болгох” асуудлыг тусгасан боловч элдэв нөлөөлөл, шахалтын улмаас сарын дараа тухайн заалтаа хүчингүй болгосон.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч гадаадын хөрөнгө оруулалттай томоохон төслүүдийн борлуулалтын орлогыг Монголбанкаар дамжуулдаг болгох, улмаар байгалийн баялгийнхаа олборлолт, борлуулалтад хяналт тавих механизмыг бий болгох зорилгоор энэхүү хуулийн төслийг санаачилсан.

Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл нь Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигладаг, Монголбанкнаас тогтоосон доод хэмжээний экспортын гадаад валютын орлоготой хуулийн этгээдийн төлбөр тооцооны дансыг Монголбанк өөр дээрээ байршуулж болох, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, валютын урсгалыг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газар, Монголбанкнаас эдгээр хуулийн этгээдтэй хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх үндсэн зорилгын хүрээнд боловсруулагдсан юм.

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн тоон үзүүлэлтээс харахад стратегийн ач холбогдол бүхий ордуудыг ашигладаг, ихээхэн хэмжээний гадаад валютын орлоготой үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай томоохон компаниуд нь гадаад валютын улсын нөөцийн хэмжээ, төлбөрийн тэнцэл, валютын захад нөлөөлөхүйц мөнгөн урсгал, гүйлгээтэй байгаа тул гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, валютын урсгалыг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газар, Монголбанкнаас эдгээр хуулийн этгээдтэй хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд Улсын Их Хурал уг хуулийн төслийг дэмжээгүй болно.

Зураг 01

Хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд:



4. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Е/09 тоот албан бичгийг Монгол Улсын Их Хурлын даргад илгээж, өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийнхээ хүрээнд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээс өөрийн мөрийн хөтөлбөр, бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт нийцээгүйг хэлэлцэх шатнаас өмнө буцаан татаж авсан. Үүнд:

- 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд;
- 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд;
- 2016 оны 6 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Мэдээллийн аюулгүй байдлын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд;
- 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Сонгогдсон болон томилогдсон өндөр албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тухай хуулийн төсөл;
- 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1.1.5. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт хориг тавих бүрэн эрхийн хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан өөрийн бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын баталсан 4 шийдвэрт хэсэгчлэн болон бүхэлд нь хориг тавьсан боловч УИХ-ын чуулганы хуралдаанаар Ерөнхийлөгчийн эдгээр хоригийг хэлэлцээд тус бүр хүлээн аваагүй болно. Үүнд:

Огноо	Хориг	Үйл ажиллагаа
2017/10/26	Улсын Их Хурлын 2017 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын 6 дахь дэд заалтад	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай” Улсын Их Хурлын 2017 оны 58 дугаар тогтоолыг 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцаад Ч.Хүрэлбаатарыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж, Засгийн газрын гишүүн-Сангийн сайдаар томилсон Улсын Их Хурлын 2017 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын 6 дахь дэд заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн хэсэгчлэн хориг тавьж буйгаа 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Е/11 тоот албан бичгээр УИХ-ын даргад хүргүүлсэн. УИХ-ын чуулганы 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Сангийн сайд Ч.Хүрэлбаатарын томилгоонд тавьсан хоригийг хэлэлцээд, хүлээн аваагүй.
2017/11/02	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцаад, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсвийн хэмжээ ба Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн хэмжээг нэмэгдүүлж, төрийн өндөр

	хуульд	<p>албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчдад 300 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгохоор тооцож, төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсвийн багцад суулгасан нь төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчим, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хуулийн зохих заалт /Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5/, тухайн зарчмын хүрээнд, тодорхой тохиолдолд төсөвт тодотгол хийхийг заасан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн хууль тус бүрд бүхэлд нь хориг тавьсан 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Е/12 тоот албан бичгийг УИХ-ын дарга М.Энхболдод хүргүүлснийг УИХ-ын чуулганы 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга чуулганы нэгдсэн хуралдаанд биечлэн оролцож, гишүүдэд хандан үг хэлж, байр сууриа илэрхийлсэн. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн аваагүй болно.</p>
2017/12/05	2018 оны Төсвийн тухай хуулийн зарлагын хэсэгт	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын 2018 оны төсвийг хэт үрэлгэн байна хэмээн үзэж, Төсвийн тухай хуулийн зарлагын хэсэгт хориг тавьсан тухай 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Е/16 тоот албан бичгийг УИХ-ын дарга М.Энхболдод илгээсэн. Уг албан бичигт Улсын Их Хурал Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийг батлахдаа тухайн төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 5,207,337.2 сая төгрөг, зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 7,710,777.6 сая төгрөг байхаар тооцож, 2,503,440.4 сая төгрөгийн алдагдалтай төсвийг баталсан нь өмнөх жилүүдэд төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 3.2-5.1 хувьтай тэнцэж байснаас давж, дотоодын нийт бүтээгдэхүүний 9.5 хувьд хүрсэн байна. 2017, 2018 оны төсвийн зарлага болон алдагдал өмнөх жилүүдийнхээс ижил түвшинд, эрс өссөн бөгөөд эдийн засаг туйлдаж хүндэрсэн гэдэг шалтгаанаар ард иргэддээ ачааны хүндийг үүрүүлэх цөөнгүй шийдвэрийг гаргасан Улсын Их Хурал төсвийн</p>

		<p>зарлагаа бууруулж, алдагдлаа багасгах тал дээр дорвитой бодлого хэрэгжүүлж, тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь онцгой анхаарал татаж байна. Төсөв батлах үйл ажиллагааг эрх зүйн талаас нь дүгнэвэл Улсын Их Хурал Монгол Улсын 2018 оны төсвийг хэлэлцэж батлахдаа Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг хамгаална”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан “төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлж, түүнд үндэслэн аль ч шатны төсвийн эрх захирагч нь төсвийн тусгай шаардлагыг хангасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслөө зохиох”, 5 дугаар зүйлийн 5.1.6-д заасан “төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх”, 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэхээр байгаа бөгөөд энэ байдал нь хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчимтай харшилж байна. Тиймээс эдгээр асуудлыг харгалзан үзэж, төсвийн бодлогоо эргэн харж, сахилга бат, хариуцлагыг эрхэмлэсэн, хэмнэлттэй, үр ашигтай төсөв батлах шаардлагатайг Улсын Их Хуралд сануулж, засах боломжийг нь олгох үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд хэсэгчлэн хориг тавьж байгаа талаар дурдсан.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг УИХ-ын чуулганы 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд хүлээн аваагүй.</p>
--	--	---

2018/6/13	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 45, 47 дугаар тогтоол	Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Улсын Их Хурлын гишүүн Дорждугарын Гантулга, Дакейн Мурат нарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцсэн Монгол Улсын Их Хурлын 2018 оны 45, 47 дугаар тогтоолуудад хориг тавих тухай 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Е/12 тоот албан бичгийг Улсын Их Хурлын дарга М.Энхболдод хүргүүлсэн. Уг албан бичигт хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтуудаар гэмт хэрэг үйлдсэн байж болох нөхцөл байдал нь тогтоогдож, яллагдагчаар татагдсан Д.Гантулга, Д.Мурат нарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэн шалгаж, гэм буруугийн асуудлыг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэх тухай Прокурорын байгууллагын саналыг Улсын Их Хурал хүлээн аваагүй нь шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах эрхэм зорилго тээсэн Монголын ард түмний хүсэл зоригт нийцээгүй, төрийн эрх барих дээд байгууллагын нэр хүнд, үнэлэмжийг улам бүр үгүй хийсэн, иргэдээ үл тоон басамжилсан, хүлээн зөвшөөрөх боломжгүй шийдвэр болсон байх тул Прокурорын байгууллагын саналыг Улсын Их Хурал дахин хэлэлцэж, Үндсэн хуульд нийцүүлэн, хариуцлагатайгаар шийдвэрлэх шаардлагатайг сануулсан.
-----------	---	---

Зураг 02



1.1.6. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Монгол

Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал томилох бүрэн эрхийн хүрээнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон гишүүдийн оронд томилогдох 3 хүнийг томилуулахаар 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 12 дугаар захирамжаар Улсын Их Хуралд санал болгосон.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа дээрх асуудлыг хэлэлцээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Ц.Нанзаддорж нарыг дэмжин, бүрэн эрхийнх нь хугацаа дууссан Д.Наранчимэг, Н.Жанцан, Т.Лхагваа нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Ц.Нанзаддоржийг 96.7, Г.Туулхүү, Б.Буяндэлгэр нарыг 98.4 хувийн саналаар дэмжин 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 35 дугаар тогтоолыг гарган, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосон 3 хүнийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсон.

2. Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно”, 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нөхөн томилогдвол түүний бүрэн эрх нь томилогдсон өдрөөс эхлэн энэ хуулийн 21.1-д заасан бүрэн эрхийн хугацаа дуустал үргэлжилнэ” гэж заасан тодорхой хуулийн зохицуулалттай.

Авлигатай тэмцэх газрын дарга Н.Ганболд, дэд дарга Б.Хурц нарыг Монгол Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 52 дугаар тогтоолоор томилсон бөгөөд 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 73 дугаар тогтоолоор Б.Хурц, 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолоор Н.Ганболд нарыг албан тушаалаас нь чөлөөлсөн ба энэ хүрээнд 2015 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 30 дугаар тогтоолоор Ц.Нямдорж нь Авлигатай тэмцэх газрын дэд даргаар, 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Х.Энхжаргал нь Авлигатай тэмцэх газрын даргаар нөхөн томилогдсон.

Нөхөн томилогдсон албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаа нь Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасны дагуу 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр дуусгавар болсон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 01 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд нийслэлийн 9 дүүрэг болон 21 аймгийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр иргэд хувийн амьдралын хүндрэл бэрхшээлээсээ илүүтэй нийгэмд шударга ёс алдагдаж, авлига, хүнд суртал газар авсныг хөндөн, энэ гажуудлыг таслан зогсоож тэмцэх үүрэгтэй төрийн байгууллага маш муу ажиллаж байгааг шүүмжлээд, Авлигатай тэмцэх газрын удирдлагуудыг солин, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, үр дүнтэй ажиллуулах санал, шаардлагыг ихээр ирүүлсэн.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.5 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Авлигатай тэмцэх газрын дарга болон дэд даргыг Улсын Их Хуралд санал болгохдоо Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан ёсны www.president.mn цахим хуудсаар 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн хооронд иргэдийн дунд нээлттэй санал асуулга явуулахад 6405 иргэн оролцож, 6382 иргэн Авлигатай тэмцэх газрын даргад 179 хүнийг, 5657 иргэн Авлигатай тэмцэх газрын дэд даргад 317 хүнийг тус тус нэр дэвшүүлж, санал өгсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга иргэдийн нэр дэвшүүлсэн хүмүүсээс хуулийн шаардлагыг хангаж, хамгийн олон санал авсан Даваанямын Даваа-Очирыг Авлигатай тэмцэх газрын даргаар, Жанжаагийн Батсайханыг Авлигатай тэмцэх газрын дэд даргаар тус тус томилуулахаар Улсын Их Хуралд санал хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/5736 тоот албан бичгээр Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар сарын 08-ны өдрийн 10/5321 тоот хариуг уламжилсан бөгөөд албан бичигт Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилсон 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 07, 2015 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 30 дугаар тогтоол нь Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг үндэслэсэн бөгөөд “нөхөн томилох тухай” гэж гараагүй байх тул Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын бүрэн эрхийн хугацаа 6 жил байхаар байна. Иймд Ерөнхийлөгчөөс ирүүлсэн саналыг хэлэлцэх нь хуульд нийцэхгүй байна гэсэн хариуг ирүүлсэн болно.

1.1.7. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Их Хурлын даргад 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Е/18 тоот албан бичгээр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” 03/03 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх, Нийслэл хотын Багануур, Багахангайгаас бусад дүүрэгт агаарын бохирдлын хэмжээ нэн аюултай түвшинд хүрсэн тул гамшгийн бүсээр тогтоож Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд “Онц байдал” зарлан тэмцэх тухай саналыг хүргүүлсэн.

Гэвч Монгол Улсын Их хурлын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/595 тоот албан бичгээр Үндсэн хууль, Онц байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль зэрэгт тодорхойлсноор Улаанбаатар хотын агаарын бохирдол нь гамшиг, аюулт үзэгдэл, осолд хамаарахгүй байх тул “Онц байдал” зарлах боломжгүй. Гэхдээ Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 212 тоот захирамжаар Улсын Их Хурал болон байнгын хороо, дэд хорооноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэх, шаардлагатай тохиолдолд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж, санал дүгнэлт гарган Засгийн газарт чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Үүний үр дүнд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаас 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар

тогтоолыг гаргаж, Засгийн газарт 7 төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон тухай хариуг ирүүлсэн.

1.1.8. Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бусад бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хуралд ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай асуудлаар дараах саналуудыг хүргүүлэв. Үүнд:

Огноо	Асуудал	Үйл ажиллагаа
2017/10/09	Ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдсон Ухнаагийн Хүрэлсүхийг Шадар сайдаар ажиллаж байх үед нь хууль бусаар мөрдөн мөшгөж, гүйцэтгэх ажиллагааны журмаар тагнан, гар утсыг нь чагнаж, бусадтай ярьсан яриаг нь бичлэг болгон улс төрийн зорилгоор олон нийтэд цацсан үйл явдал”-ыг Монгол Улсын иргэний халдашгүй чөлөөтэй байх үндсэн эрхийг зөрчсөн зүй бус үйл ажиллагаа хэмээн үзэж, гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй хуулийн байгууллагууд, тэдгээрийн удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэх асуудлыг хөндөн ерөнхий хяналтын сонсгол явуулах хүсэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу Монгол Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг бататган хамгаалах, улс төрийн зорилгоор хууль зөрчиж, балмад үйл ажиллагаа явуулах болсон хуулийн байгууллагуудын зүй бус үйл ажиллагааг хазаарлах, төрийн өндөр албан тушаалтныг бүдүүлгээр тагнан мөрдөж байгаа төр энгийн иргэдээ бүр илүү хянан мөрдөж чадна гэсэн ойлголтын хүрээнд бий болсон нийгмийн айдас, түгшүүрийг арилгах өндөр ач холбогдолтой байсан юм. Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч хүсэлт гаргасан тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг заавал явуулах тухай тодорхой заасан боловч Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Улсын Их Хурлын дарга хууль зүйн үндэслэлгүйгээр ерөнхий хяналтын сонсгол явуулахаас татгалзсан хариу өгсөн.</p>
2017/10/09	Ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга төрийн албыг арилжаалсан “60 тэрбум”-ын нийтэд илэрхий болсон хэргийг эцэслэн шийдвэрлэх үндсэн чиг үүргийн ажлаа хангалтгүй хийж байгаа хуулийн байгууллагууд,</p>

		<p>тэдгээрийн удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэх асуудлыг хөндөн ерөнхий хяналтын сонсгол явуулах хүсэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу Монгол Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн. Энэ нь төрийн эрхийг хууль бусаар авах буюу авахыг санаархсан бусармаг үйл ажиллагааг дахин гаргуулахгүйгээр таслан зогсоох, шударга төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн албаны мерит тогтолцоог бэхжүүлэх зэрэг онцгой ач холбогдолтой байсан. Харин Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Улсын Их Хурлын даргын зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгч хүсэлт гаргасан тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг заавал явуулах тухай хуулийн заалтыг мөн зөрчиж, сонсгол явуулахаас татгалзсан хариу өгсөн.</p>
--	--	---

1.1.9. Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 6 сарын 28-ны өдрийн Е/14 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы хугацааг сунгах тухай саналаа Улсын Их Хурлын дарга М.Энхболдод хүргүүлсэн.

Улс оронд тулгамдаад буй асуудлыг цаг алдалгүйгээр хэлэлцүүлэх, шийдвэрлэх, тухайлбал Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглаж үлэмж хэмжээний экспортын гадаад валют олдог “Оюутолгой” зэрэг компаниудын төлбөр тооцооны дансыг өөр дээрээ байршуулах эрхийг Монголбанканд олгох замаар баялгийнхаа олборлолт, хувь эзэмшсэн компанийнхаа орлого, зарлагын талаар тодорхой мэдээлэлтэй болж, валютын нөөц, урсгалаа нэмэгдүүлэх онцгой ач холбогдол бүхий “Валют зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль”-ийг хэлэлцэх, мөн төрийн албыг арилжаалсан гэх “60 тэрбумын” хэргийг хууль тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих онцгой бүрэн эрх бүхий байгууллагын хувьд нээлттэй сонсгол хийх, уг асуудлыг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэх шаардлагатай байх тул Улсын Их Хурлын даргын бүрэн эрхийнхээ хүрээнд ээлжит чуулганы хугацааг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт зааснаар сунгаж өгөхийг хүссэн.

Гэвч Улсын Их Хурлын даргын 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 1/8529 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн “Валют зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль”-ийг 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны, 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй бөгөөд Улсын Их хурлын 68 дугаар тогтоолыг гарган хариу мэдэгдсэн.

Улсын Их Хурлын нэр бүхий 19 гишүүнээс гаргасан “Төрийн албыг арилжаалсан 60 тэрбумын гэх хэргийн талаар нээлттэй сонсгол хийх” асуудлыг

Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн бөгөөд тус хороо хэлэлцээд Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт “Байнгын хорооны хуралдааныг чуулганы чөлөө цагт зохион байгуулж болно”, Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51¹ дүгээр зүйлийн 51^{1.2} дахь хэсэгт “Нийтийн сонсголыг нэгдсэн болон тухайн байнгын, дэд, түр хорооны хуралдаантай давхардуулахгүйгээр зохион байгуулах бөгөөд Улсын Их хурлын чуулганы чөлөөт цагт зохион байгуулж болно” гэж заасны дагуу шийдвэрлэх боломжтой талаар дурдсан хариу ирүүлсэн.

Мөн Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганыг сунгах асуудлаар Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Улсын Их хурлын ..., хаврын ээлжит чуулган 4 дүгээр сарын 05-ны өдрөөс мөн оны 7 дугаар сарын 1-ний хооронд тус тус хуралдана” гэж заасныг үндэслэн Улсын Их хурлын даргын дэргэдэх зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэж шийдвэрлэснээр Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган 6 дугаар сарын 29-ний өдөр өндөрлөсөн талаар хариуг тус тус ирүүлсэн болно.

1.1.10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгсэлээр нийтэд мэдээлнэ” хэмээн заасны дагуу 2017 оны 7 дугаар сарын 10-наас эхлэн нэг жилийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 45 зарлигийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэл болон www.legalinfo.mn сайтад бүрэн эхээр нь нийтлүүлж, олон нийтэд мэдээлэв.

1.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Засгийн газартай харилцаж ажилласан талаар:

1.2.1.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай Ерөнхий сайдаас тавьсан саналын талаар түүнтэй зөвшилцөх бүрэн эрхийн хүрээнд:

1. Монгол Улсын Ерөнхий сайд Жаргалтулгын Эрдэнэбат 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн ЗГ-1/115 тоот “Санал хүргүүлэх тухай” албан бичгийг Шадар сайд Ухнаагийн Хүрэлсүхийн өөрийнх нь ажлаас чөлөөлүүлэх хүсэлтэд санал авахаар ирүүлсэн.

Уг албан бичигт танилцуулга, Улсын Их Хурлаар хэлэлцэгдэх тогтоолын төслийг хавсарган ирүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга төрийн тэргүүн, ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд Шадар сайдын ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргах болсон шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл авсны үндсэн дээр шийдвэр гаргах шаардлагатай гэж үзсэн.

Мөн албан бичигт Шадар сайдын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг хавсаргаагүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу

зөвшилцөх нөхцөл бүрдээгүй гэж үзэн, 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн Е/03 тоот албан бичгээр буцаасан болно.

2. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2017 оны 10 дугаар 12-ны өдөр Засгийн газрын гишүүдийг зөвшилцөх тухай ЗГ-1/139 тоот албан бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад ирүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч уг албан бичигт уул уурхайн бизнест тодорхой ашиг сонирхолтой Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдад томилох саналыг хүлээн авах боломжгүй тул бусад гишүүдийг УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн хариуг 2017 оны 10 дугаар сарын 17-ны Е/10 тоот албан бичгээр мэдэгдэж, тухайн өдөр Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх болон Засгийн газрын гишүүн, сайдад нэр дэвшсэн УИХ-ын гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хүлээн авч уулзан өөрийн байр сууриа илэрхийлсэн.

Улсын Их Хурлын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Улсын Их Хурлын 2017 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын 6 дахь дэд заалтад Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн хэсэгчлэн хориг тавьж буйгаа 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Е/11 тоот албан бичгээр УИХ-ын даргад хүргүүлсэн.

УИХ-ын чуулганы 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Сангийн сайд Ч.Хүрэлбаатарын томилгоонд тавьсан хоригийг хэлэлцээд, хүлээн аваагүй болно.

1.2.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан өөрийн бүрэн эрхэд хамаарах бусад асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх эрхийн хүрээнд:

1. Дотоодын цэргийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасны дагуу Дотоодын цэргийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Дотоодын цэргийн анги байгуулах тухай саналыг зөвшилцөхөөр Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 8 дугаар сарын 24-ний өдөр ЗГ-1/117 тоот албан бичгээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид ирүүлсэн.

Уг саналын хариуд Монгол Улсын Ерөнхийлөгч 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Е/05 албан бичгийг илгээж, зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлэн уг асуудлаар авч хэрэгжүүлбэл зохих гурван саналыг хүргүүлсэн. Үүнд:

- Дотоодын цэргийн ангийг шинээр байгуулж байгаатай холбогдуулан цэргийн анги байгууллагын дотоод дүрэм, журам, зэвсэг, галт хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, харуулын албаны болон бусад дүрэм журмуудыг Зэвсэгт хүчний тухай хууль, тогтоомжуудтай нийцүүлэн баталж мөрдүүлэх;

- Нийгмийн хэв журмыг сахиулах ажиллагаанд дотоодын цэргийг оролцуулахдаа Цагдаагийн ерөнхий газрын даргын танилцуулснаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын шийдвэрийн үндсэн дээр хэрэгжүүлдэг байх;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд нийгмийн хэв журмыг хангах ажиллагаанд дотоодын цэргийг оролцуулах шийдвэр гаргахдаа зөвхөн холбогдох хууль, журам, зааварт тусгагдсан тодорхой нөхцөлүүдийг үндэс болгох зэрэг зарчмын асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналуудыг хүргүүлсэн.

2. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 7-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд нь Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийн бодлого болон гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцдаг.

Бага насны хүүхдийг хүчирхийлэх, бэлгийн дур хүслээ хангах хэрэгсэл болгох асуудал нийгмийн өмнө хурцаар тулгарч байгаа тул дээрх чиг үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд олон улсын туршлагад үндэслэн Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг нэмэх, Үндсэн хуулийг хэрэгжүүлэх, харшилж буй олон улсын гэрээ, конвенцоос гарах ажлыг зохион байгуулж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Е/15 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй болно.

1.2.3. Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд зааснаар Засгийн газрын хуралдаанд өөрийн тааллаар оролцож, санал бодлоо илэрхийлэх эрхийн хүрээнд:

Засгийн газрын хуралдаанд Ерөнхийлөгчийн зөвлөхүүдээр төлөөлүүлэн хэлэлцэх асуудлуудад тухайлсан санал оруулж, байр сууриа илэрхийлж ажиллав.

1.3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Шүүх эрх мэдлийн байгууллагатай харилцаж ажилласан талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 51.2-т "... бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно...", Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 16-д "Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилно", Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилно" гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга зарлиг гарган, анхан шатны шүүхэд 1 шүүгчийг шинээр томилж, өндөр насны тэтгэвэрт гарсан, өөрөө хүсэлт гаргасан, нас барсан зэрэг шалтгаанаар 11 шүүгчийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, 8 шүүгчийг өөрсдийнх нь хүсэлтээр шилжүүлэн томилов.

1.4. Монголын ард түмний эв нэгдэл, үлс орны эдийн засаг, үлс төрийн тогтвортой байдлыг хангах, шаардлагатай гэж үзвэл бусад асуудлаар Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргах эрхийн хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга үндэсний хэмжээний арга хэмжээ (хурал зөвлөгөөн, чуулга уулзалт, ойн баяр гэх мэт)-нд оролцогсдод хандан баяр хүргэж, амжилт гаргах, шийдвэрлэвэл зохих асуудалд анхаарлаа хандуулахыг хүсэж 38 илгээлт хүргүүлэв. Үүнд:

№	Огноо	Арга хэмжээ
1.	2017/07/20	"Бурхан багшийн айлдвар: Монгол Ганжуурын судалгаа" олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогчдод
2.	2017/07/20	Баянхонгор хотын 60 жилийн ойд оролцогчдод
3.	2017/07/28	Хан Хөхий уулын тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолд оролцогчдод
4.	2017/07/28	Ази, Номхон далайн бүсийн скаутын 31 дүгээр Жемборид оролцогчдод
5.	2017/08/07	Хамаг Монгол чуулганы үйл ажиллагаанд оролцогчдод
6.	2017/08/18	Монгол Улсад Үйлдвэрчний Эвлэлийн хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойд
7.	2017/09/15	Монгол Улсын Төрийн шагналт зохиолч, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Пүрэвийн Хорлоогийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн болон эрдэм шинжилгээний хуралд оролцогчдод
8.	2017/09/27	Академич Цэвэгийн Тойвгоогийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан "Мал эмнэлэг, биологийн шинжлэх ухааны ололт, өнөөгийн түвшин" олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцогчдод
9.	2017/09/27	"Олон нийтийн телевизийн хөгжлийн чиг хандлага" олон улсын форумд оролцогчдод
10.	2017/09/29	Монгол Улсын Эрчим хүчний салбарын 95 жилийн ойн баярын хуралд оролцогчдод
11.	2017/10/05	Нийслэлийн шүүхийн 90 жилийн ойн баярын хуралд оролцогчдод
12.	2017/10/05	Анагаахын шинжлэх ухааны Үндэсний их сургуулийн 75 жилийн ойн хүндэтгэлийн баярын хуралд оролцогчдод
13.	2017/10/06	Монгол Улсын Их Сургуулийн түүхт 75 жилийн ойн "Эрдэмд түүчээлсэн 75 жил" ёслол, хүндэтгэлийн хуралд оролцогчдод
14.	2017/10/10	"Экспо Монголиа" олон улсын үзэсгэлэн, тогтвортой хөгжлийн бага хуралд оролцогчдод
15.	2017/10/13	"Дэлхийн цагаан таягтны өдөр"-т

16.	2017/10/13	Хүний нөөцийн ажилтны зөвлөгөөнд оролцогчдод
17.	2017/10/21	Хөдөө аж ахуйн хоршооллын төв байгууллага үүсгэн байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээнд оролцогчдод
18.	2017/10/27	Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 75 жилийн ойд
19.	2017/11/03	"Монголын түүх, сурвалж бичгийн судалгаа" олон улсын хуралд оролцогчдод
20.	2017/11/10	Монгол Улсын Төрийн хошой шагналт зохиолч, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Чадраабалын Лодойдамбын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан "ХХ зууны Монголын уран зохиолын үнэт зүйл-Ч.Лодойдамба" эрдэм шинжилгээний хуралд оролцогчдод
21.	2017/11/25	Монголд театрын дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 60 жилийн ойн баярын хуралд оролцогчдод
22.	2017/11/28	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн LEAD Talks төслийн оролцогчдод
23.	2017/11/29	Соёл, урлагийн ажилтны улсын 2 дугаар чуулганд оролцогчдод
24.	2017/12/05	Монгол Улсад орчин цагийн архивын алба үүсэж хөгжсөний 90 жилийн ойн баярын хуралд оролцогчдод
25.	2017/12/08	Монголын уламжлалт анагаах ухааны олон улсын их хуралд оролцогчдод
26.	2017/12/16	Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгуулагдсаны 30 жилийн ойд
27.	2017/12/22	Төмөр замчдын төв хэвлэл "Ган зам" сонины 60 жилийн ойд
28.	2018/02/16	Цагаан сарын мэндчилгээ
29.	2018/03/08	Алдарт эхийн одонт ээжүүдийн чуулга уулзалтад оролцогчдод
30.	2018/03/16	Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 97 жилийн ойн баярын хуралд оролцогчдод
31.	2018/03/24	Монгол-Оросын хамтарсан Ерөнхий боловсролын сургуулийн 25 жилийн ойн баярын хуралд оролцогчдод
32.	2018/04/13	Монгол-Японы соёлын арга хэмжээнд оролцогчдод
33.	2018/05/03	"Хараат бус сэтгүүлзүй" үндэсний форумд оролцогчдод
34.	2018/05/10	Таеквондогийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдод
35.	2018/06/22	Их Тахилгат хайрхны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолд оролцогчдод
36.	2018/06/27	Эрдэнэт үйлдвэрийн 40 жилийн ойн баярын хуралд оролцогчдод
37.	2018/07/02	Олон улсын буриад зоны "Алтаргана" XIII наадамд оролцогчдод

ХОЁР. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, УЛСЫГ БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүний хувьд:

Үндсэн ажлын хүрээнд: Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Х.Баттулга Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох Оршин тогтнохуйн аюулгүй байдал, Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал, Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдал, Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал, Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, Экологийн аюулгүй байдал, Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр улс үндэсний аюулгүй байдал болон төрийн гадаад, дотоод бодлогын нэгдмэл байдлыг хангах үүднээс дүн шинжилгээ судалгаатай, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх санал боловсруулан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг 6 удаа хуралдуулж, 15 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 21 зөвлөмж, 13 тэмдэглэл гарган, Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж, үүрэг даалгавар, чиглэл хүргүүлсэн байна.

Зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг эрхэлсэн ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн анхдугаар хуралдаан 1992 оны 8 дугаар сарын 08-ны өдөр болсноос хойш эдүгээг хүртэлх хугацаанд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудыг илээр хэлэлцэн 384 заалт бүхий 154 шийдвэр шийдвэрүүдийг хэрэгжилтийг дүгнэх ажлыг зохион байгуулсан байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлыг бүхэлд нь удирдан зохион байгуулж, үйл ажиллагаатай холбоотой Зөвлөлийн хуралдааны дэг, ажлын дэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцэх асуудлын жагсаалт, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтарсан төлөвлөгөө, Ажлын албаны бүтэц бүрэлдэхүүн, төсөв, орон тооны болон орон тооны бус шинжээч томилох, холбогдох журам, шаардлагатай асуудлаар ажлын хэсэг байгуулах зэрэг чиглэлүүдээр нууцын зэрэгтэй 9, илээр 5, нийт 14 зарлиг, захирамж гаргаж, өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Зөвлөлийн чиг үүрэгт хамаарах, аюулгүй байдлын тулгамдсан асуудалд анхаарал хандуулан ажиллах талаар Монгол Улсын Их Хурлын хаалттай хуралдаанд мэдээлэл хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч ОХУ-ын Сочи хотноо зохион байгуулагдсан Аюулгүй байдлын асуудал эрхэлсэн өндөр албан тушаалтнуудын Олон улсын IX чуулган, БНХАУ-ын Чиндао хотод зохион байгуулагдсан ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүнүүдийн уулзалтад оролцсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Х.Баттулгын 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн иргэдтэй уулзах уулзалтад Ажлын албанаас чиглэл хариуцсан албан тушаалтнууд оролцож, үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашигтай холбоотой асуудлаар иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдлын хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын удирдлагатай уулзаж, аюулгүй байдалтай холбоотой шуурхай мэдээ, танилцуулах мэдээ, тайлан мэдээний мэдээ, мэдээллийн урсгалыг сайжруулах чиглэлээр уулзалтуудыг зохион байгуулсан байна.

Зөвлөлийн 2015 оны №40/22 дугаартай “Онцгой нөхцөл байдал бий болсон үед байгууллагууд харилцан ажиллах журмын тухай” зөвлөмжийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн мн/03 дугаар зарлигийн хавсралтаар “Онцгой нөхцөл бий болсон үед байгууллагууд харилцан ажиллах журам”-ыг баталж, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 491 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Онцгой нөхцөл байдал бий болсон үед зэвсэгт хүчин, тагнуул, хил хамгаалах, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах ерөнхий төлөвлөгөө”-г батлуулж, журам, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахын хүрээнд Тагнуулын ерөнхий газрын Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлөөс 2018 оны 3 дугаар сарын 29-31-ний хооронд зохион байгуулагдсан “Хаан шонхор” команд штабын сургалт, Онцгой байдлын ерөнхий газар, Монгол Улсад суугаа АНУ-ын Элчин сайдын яам, Энэтхэг, Номхон далайн цэргийн командлал, Аляскийн үндэсний гвард зэрэг байгууллагуудаас 2018 оны 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 08-ны өдрүүдэд хамтран зохион байгуулсан “Говийн чоно-2018” олон улсын сургалт, дадлага сургуулийн ерөнхий төлөвлөгөө болон байгууллагуудын чиглэлийн төлөвлөгөөнд тодотгол хийж, төлөвлөж буй нэгдсэн дадлагын төлөвлөгөөтэй танилцаж, тусгайлсан чиг үүрэгтэй бусад байгууллагатай хамтран ажиллах талаар чиглэл өгөв.

Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд хэлэлцэх асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд урьдчилан танилцуулж байх, “Угийн бичгийн өв соёлыг сэргээн хөгжүүлэх тухай”, “Монгол бичиг, үсгийн юникод” зэрэг асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг 2018-2020 онд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөг боловсруулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Х.Баттулга түүх, соёлын дурсгалт газар, түүний өвийн хадгалалт, хамгаалалтын

асуудлыг хөндөн “Богд хааны ордон музей”-н өвийн хамгаалалтын бүсэд хууль бусаар давхцуулж, газар олгосон асуудалтай газар дээр нь танилцаж, уг асуудлыг шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг даргад үүрэг болгосон. Нийслэлийн Засаг дарга шийдвэр гаргаж, аж ахуйн нэгжид олгосон газрын гэрчилгээг хүчингүй болгосон байна.

2.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид төрийн цэргийн байгууллагын Улаанбаатар цэргийн хүрээний бие бүрэлдэхүүн хүндэтгэл үзүүлэх Цэргийн ёслолын жагсаал 2017 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд болоход Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга оролцож, цэргийн бие бүрэлдэхүүнтэй мэндчилж, үг хэлэв.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Х.Баттулга 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдөр Батлан хамгаалах яаманд ажиллаж, Бүх цэргийн Их хар сүлдний өргөөнд зочлон, Бүх цэргийн Их хар сүлдэнд хүндэтгэл үзүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч Батлан хамгаалах яаманд ажиллах үеэрээ тус яамны удирдлагуудтай батлан хамгаалах салбарын үйл ажиллагааны талаар санал солилцон ярилцав.

3. Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, цэрэг-аюулгүй байдлын олон тулгуурт хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Монгол Улсад уламжлал болгон зохион байгуулагдаж, хамрах хүрээ нь жилээс жилд өргөжиж байгаа “Хааны эрэлд” энхийг дэмжих ажиллагааны олон улсын ээлжит хамтарсан сургуулийн нээлт 2017 оны 7 дугаар сарын 27-ны өдөр, 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Тавантолгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд тус тус болоход Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга оролцон, дэмжлэг үзүүлэх, сургалт бэлтгэлийн чанар үр дүнтэй нь танилцах ажлыг зохион байгуулав.

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 01 дүгээр зарлигаар “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ыг баталж, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабт журмыг мөрдөж ажиллах, хэрэгжилтийг хангахыг үүрэг болгосон. Дорноговь аймгийн Сайншанд сумыг тус аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулагдах газрын тос боловсруулах үйлдвэртэй холбох 16.36 км, явгалсан хэсгийн өргөн нь 9 м, 5 эргэлттэй, 22 гүүр, бетонон хоолойтой, хүнд даацын машин, техник зорчиход тэсвэртэй бетонон хольцоор хүч нэмэгдүүлсэн, хатуу хучилттай зам тавих ажлыг уг журмын дагуу Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн хамт 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж байна.

5. 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Х.Баттулга генералуудтай уулзаж, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг хөндөн ярилцаж, “Бүтээн байгуулалт-Монгол цэрэг” хөтөлбөрийг дэлгэрэнгүй танилцуулан, санал солилцов.

6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 93 дугаар зарлигийн дагуу “Оюутан цэрэг” хөтөлбөр 2013-2016 онд 4 жил амжилттай хэрэгжсэн. 2016 онд батлагдсан Цэргийн албаны тухай хуулийн 7.7, 7.9-д Цэргийн сургуулиас бусад их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эрэгтэй суралцагч сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдаж болох ба “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмыг Засгийн газар батлахаар зааснаар тус хөтөлбөрийн эрх зүйн үндсийг хуульчлан баталгаажуулсан. “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад 2017, 2018 онд тус бүр 1000 оюутан хамрагдаж, сургалтад ашиглах сурах бичиг, гарын авлагыг бэлтгэн, сургалт, бэлтгэлийг Улаанбаатар хот, Дорнод, Ховд аймгийн цэргийн анги, салбарт түшиглэн зохион байгуулав. Сургалт үргэлжлэх хугацаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын зүгээс явцтай танилцаж, нээлт, хаалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн оролцов.

7. Батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэл, Батлан хамгаалахын багц хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн төслийг Батлан хамгаалах яамнаас боловсруулан өргөн мэдүүлснийг УИХ-ын чуулганы 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталж, Батлан хамгаалах яам, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүлээлгэн өгсөн. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Ерөнхийлөгчийн Тамгын газраас төлөөлөл оролцон ажилласан. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль шинээр батлагдсан бол 1998 онд батлагдсан Дайчилгааны тухай хуулийг 2015 онд УИХ-аар шинэчлэн батлагдсан Батлан хамгаалах бодлогын үндэс, баримт бичиг болоод батлан хамгаалахын багц хуулиудад нийцүүлэн өөрчлөн шинэчилсэн юм.

Орон нутгийн хамгаалалтын тухай хууль батлагдсанаар Монгол Улсын иргэний үндсэн үүрэг болох “Эх орноо хамгаалах” гэсэн Үндсэн хуулийн санаа энэхүү хуулиар хэрэгжиж, орон нутгийн хамгаалалтын харилцаа, төрийн байгууллага, иргэн хуулийн этгээдийн хүлээх үүрэг хуульчлагдсан. Мөн Монгол Улсын өөрийгөө хамгаалах чадавхыг бэхжүүлэх, иргэн-цэргийн харилцааг төлөвшүүлэх орон нутгийн нийгэм эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх замаар батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх боломж бүрдэнэ. Харин Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль батлагдсанаар улс орны эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэх үед хэрэгжүүлэх арга хэмжээ илүү боловсронгуй болж, дайчилгааны талаарх субъектүүдийн чиг үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоо, бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлох эрхзүйн орчин бүрдэж байгаа юм. Дайчилгаанд оролцогчдын эрх зүйн байдлын баталгааг хангахаас гадна хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилах учиртай.

8. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр 49 дугаар зарлигийг гаргаж, 2012 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм батлах тухай” зарлигийг хүчингүй болсонд тооцсон.

9. Батлан хамгаалахын багц хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цэргийн номлол, нийтлэг дүрэм, журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шинэчлэн батлуулахаар Батлан хамгаалахын яам, төрийн цэргийн байгууллагуудаас өргөн барьсныг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хамтран судалж байна.

10. Хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар болон хууль сахиулах байгууллагуудын сарын ажлын үр дүнгийн мэдээ, тайлантай сар бүр танилцаж, үүрэг чиглэл өгч ажиллав.

11. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын дотоод аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэл, нөхцөл байдлын талаар анхаарч, хар тамхи, мансууруулах бодис, хулгай, улс үндэстэн дамнасан гэмт хэрэг, нийгмийн хэв журмын нөхцөл байдал зэрэг анхаарал татсан асуудлуудын талаар тусгайлсан танилцуулга, судалгааг холбогдох байгууллагуудаас гаргуулан авч, үүрэг чиглэл өгч, биелэлттэй нь танилцлаа.

ГУРАВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД

Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсыг гадаад харилцаанд бүрэн эрхтэй төлөөлж, гадаад бодлого, олон улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулах чиглэлийг барьж ажиллав. Үүний дүнд олон улс болон бүс нутгийн хэмжээнд Монгол Улсын байр суурь, нэр хүндийг бэхжүүлэх, сурталчлан таниулах, Монгол Улс тогтвортой хөгжих гадаад таатай орчныг бэхжүүлэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд тодорхой ахиц гарсан гэж дүгнэж байна.

3.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж ажилласан талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад улсад хийсэн айлчлалын талаар:

3.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины ивээл дор Владивосток хотноо 2017 оны 9 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дорнын эдийн засгийн III чуулга уулзалтад урилгаар оролцож, ОХУ-д ажлын айлчлал хийв.

Тус чуулга уулзалтад оролцохдоо ОХУ-ын эдийн засгийн хөгжил, түүний дотор Алс Дорнодын хөгжил – Ази, Номхон далайн орнуудын хөгжлийн шинэ боломж, хамтын ажиллагааны чиг хандлага, Зүүн Ази, Ази, Номхон далайн бүс нутгийн бодлогын талаар мэдээлэл солилцох, Монгол Улсад хөрөнгө оруулах, харилцан ашигтай хамтран ажиллах нөөц боломжийг ОХУ болон чуулга уулзалтад оролцогч бусад орны төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөгч нарт таниулахад оршиж байв. Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад анх удаа Монгол Улс Ерөнхийлөгчийн түвшинд оролцож байгаа нь манай тал ОХУ-тай хөгжүүлж байгаа харилцаанд чухал ач холбогдол өгч буйг нотлохын зэрэгцээ Монгол, Оросын стратегийн түншлэлийн харилцааг шинэ агуулгаар баяжуулах, хамтын ажиллагааг бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэхэд тодорхой түлхэц үзүүлэхэд чиглэсэн болно.

Владивосток хотноо Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтэй хэлэлцээ хийв. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад ОХУ-ын Ерөнхийлөгчийн туслах И.Е.Левитин, Аж үйлдвэр, худалдааны сайд Д.В.Мантуров, Хөдөө аж ахуйн орлогч сайд Е.В.Громыко, Приморын хязгаарын Амбан захирагч В.В.Миклушевский, Бүгд Найрамдах Тува Улсын тэргүүн Ш.В.Караоол, Бүгд Найрамдах Саха Улсын тэргүүн Е.А.Борисов нар тус тус бараалхав. Түүнчлэн ОХУ-ын томоохон компаниуд болох “Ренова” группийн Ерөнхийлөгч В.Ф.Вексельберг, “Русал” компанийн Ерөнхийлөгч О.В.Дерипаска нартай уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-д хийсэн ажлын айлчлалын хүрээнд Восточный боомтод зочилж, нүүрс буулгалтын үйл ажиллагаа, техникийн удирдлагын нэгдсэн төв, шинээр баригдаж буй нүүрс ачих терминалын бүтээн байгуулалттай танилцав. ОХУ-ын Ерөнхийлөгчийн туслах И.Е.Левитин, ОХУ-ын Тээврийн сайд М.Ю.Соколов тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгчийг дагалдан явав.

Нэг. ОХУ-д хийсэн ажлын айлчлал: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нарын албан ёсны хэлэлцээний үеэр хоёр тал Монгол, Оросын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, хэтийн төлөвийн талаар санал солилцов. Хоёр орны улс төрийн харилцаа стратегийн түншлэлийн үзэл санааны дагуу өндөр түвшинд хөгжиж, яриа хэлэлцээ бүхий л салбарт идэвхжиж байгаад сэтгэл хангалуун буйгаа талууд илэрхийлэв.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин хоёр орны уламжлалт салбаруудыг үргэлжлүүлэн хөгжүүлэхийн төлөө буйгаа нотолж, цаашид хамтын ажиллагааны шинэ боломжуудыг эрэлхийлэх, мөн Монголын зах зээлд ОХУ-ын компаниуд бүхий л салбарт өрсөлдөхөд бэлэн буйгаа илэрхийлж, ингэхдээ бусад хөрөнгө оруулагчид олгодгоос илүү тааламжтай нөхцөл шаардахгүй гэдгээ илэрхийлсэн.

Жүдогийн спортын нийтлэг сонирхол нь хоёр Ерөнхийлөгч ажил хэргийн харилцаа тогтооход хувь нэмрээ оруулна хэмээн итгэлтэй байна гэж ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин тэмдэглэв.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин хоёр орны харилцаанд эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлж буйг дурдаад “Росатом” компани Монголтой хамтран ажиллах сонирхолтой байгаа, энэ нь зөвхөн атомын эрчим хүчээр хязгаарлагдахгүй, эрүүл мэнд зэрэг бусад салбарыг хамарч байгааг дурдсан. Мөн төмөр замын ачаа, тээвэр чухал болохыг тэмдэглэж, “УБТЗ” компанийг талууд дэмжиж ажиллах нь зүйтэй гээд, өмнө нь “УБТЗ”-аас өөрийн хэрэгцээний түлшинд төлж ирсэн онцгой албан татварыг буцааж олгох, төмөр замын тарифыг индексжүүлэх хэрэгтэй гэж хэлэв. Мөн хоёр улсын хөдөө аж ахуй, батлан хамгаалах, бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаа, соёл, боловсролын асуудлыг хөндөж ярив.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн бүртгэл шийдэгдэхгүй удаж байгааг дурдаж, асуудлыг шийдэх үүднээс Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах санал тавив. Мөн тэр бээр Монголд эрчим хүчний эх үүсвэр шаардлагатай байгааг ойлгож буйгаа дурдаад Байгал нуур бол дэлхийн өв учраас талууд харилцан ашигтай, алсыг харсан шийдвэр гаргах хэрэгтэй гэв.

Монгол Улсыг АНДЭЗХАБ (АПЕК)-т нэгдэх сонирхолтойг мэднэ, иймд энэ чиглэлд дэмжиж ажиллах болно гэдгээ Оросын тал илэрхийлэв.

Сэлэнгэ мөрний ай савд баригдахаар яригдаж буй УЦС зэрэг асуудлууд байгааг онцолж, талууд зохих шийдвэрт хүрнэ гэдэгт итгэж буйд санал нэг байв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улс нь ОХУ-ын Алс Дорнодоос холгүй байрлаж байгаа нь тус бүс нутгийн эдийн засгийн хөгжилд нэгдэн орох өргөн боломжтой болохыг тэмдэглэв. Цаашид Монгол, Оросын уламжлалт найрсаг харилцааг бүхий л салбарт хөгжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах тэргүүн зорилт тавьж ажиллаж буйгаа мэдэгдсэн.

1990-ээд оноос хойш Монгол Улсад хоёр хөрштэй харилцах баланс алдагдаж, БНХАУ-ын нөлөө нэмэгдсэнийг дурдаж, цаашид энэхүү балансыг тэнцвэржүүлэхэд ОХУ-тай хамтран ажиллах хүсэлтэй буйгаа Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга тэмдэглэн хэлэв.

Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн холбооны хооронд хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж буйг талууд цохон тэмдэглэв. Монгол Улс, Евразийн Эдийн засгийн Холбоо хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах судалгааны ажил эхлүүлэх Монголын талын эрмэлзлийг ОХУ-ын зүгээс дэмжиж буйд талархал илэрхийлсэн.

Хэлэлцээний үеэр ОХУ-аас 100 тэрбум рублийн хөнгөлөлттэй зээл авч, уг зээлийг зөвхөн УБТЗ-ын шинэчлэлд ашиглах саналыг Монголын тал тавьсан. Мөн ОХУ-ын Алс Дорнодын боомтуудыг ашиглан Монголын бараа, бүтээгдэхүүн, түүний дотор нүүрсийг Зүүн Азийн зах зээлд гаргахад Монгол, Орос, Японы хамтарсан компани байгуулах саналыг дэвшүүлэв. “Төмөр замаар ачаа дамжуулан тээвэрлэх нөхцөлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг аль болох ойрын

хугацаанд байгуулах нь энэхүү гуравласан хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал түлхэц үзүүлнэ гэж үзэж буйгаа Монголын тал илэрхийлэв.

Олон жил яригдаж буй Монгол Улс дахь Оросын үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх ёстой, мөн усан цахилгаан станц барихтай холбоотой асуудлаарх судалгаа болон саналуудыг судалж үзэж байгаа гэдгээ Монголын тал илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Аж үйлдвэр, худалдааны сайд Д.В.Мантуров нарын уулзалтаар ОХУ-ын хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн үзэсгэлэнг 2018 оны 3-4 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулахаар тохирсон.

ОХУ-ын Хөдөө аж ахуйн орлогч сайд Е.В.Громыко бараалхах үеэрээ Монголын талын хүсэлтийн дагуу шаардлагатай вакциныг үйлдвэрлэж, бүрэн нийлүүлэхэд хоёр сар орчмын хугацаа хэрэгтэйг тэмдэглээд, 11 дүгээр сар гэхэд Монгол Улсад хүйтний эрч нэмэгдэж, энэ үеэр малыг вакцинжуулах нь үр дүн багатай болох учир вакцины үйлдвэрлэлтийг үргэлжлүүлэх эсэх асуудлаар Монголын талаас яаралтай чиглэл ирүүлэхийг хүссэн.

ОХУ-ын Бүгд Найрамдах Тува Улсын тэргүүн Ш.В.Кара-оол Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхах үеэр байгуулахаар төлөвлөж буй Кызыл – Курагино чиглэлийн төмөр замыг цаашид Монгол Улсын баруун бүс нутгаар дамжуулан БНХАУ руу төмөр замын гарц нээх чиглэлээр ажиллаж буйгаа мэдээлж, энэ асуудлаар Монголын талтай нягт хамтран ажиллах сонирхолтой буйгаа илэрхийлэв.

ОХУ-ын Бүгд Найрамдах Саха Улсын тэргүүн Е.А.Борисов Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхаж, “Азийн хүүхдүүд” спортын наадам 2020 онд Улаанбаатар хотноо зохион байгуулахаар болсонд талархал илэрхийлж, цаашид Монгол, Якутын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Якутад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдэд Монгол Улсыг татан оролцуулах боломжийг хамтран судлах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, Монгол-Якут, Якут-Монгол чиглэлийн морин аяллыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийг хүссэн.

Оросын тал уулзалтуудын үеэр 2025 онд болох Олон улсын “Экспо” үзэсгэлэнг зохион байгуулахад ОХУ-ын Екатеринбург хот нэрээ дэвшүүлж буйг мэдээлж, Монголын талаас дэмжлэг үзүүлэхийг хүссэн болно.

Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-д жүдо бөх үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээ болон Алс Дорнодын Холбооны Их сургуулийн дэргэд байгуулах Олон улсын тулааны урлагийн ордны шав тавих ёслолд оролцож, ирээдүйн үеийнхэнд зориулсан илгээлтийг гардуулав. Мөн Владивосток хотын “Фетисов Арена” спортын цогцолборт болсон Жигоро Каногийн нэрэмжит олон улсын тэмцээний хаалтын ажиллагаанд оролцов.

Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Х.Баттулга Оросын “Известия” сонинд ярилцлага өгч, ОХУ-ын спортын сэтгүүлчидтэй өглөөний цай барьж, уулзалт хийсэн болно.

Хоёр. Дорнын эдийн засгийн чуулга уулзалт: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын эдийн засгийн III чуулга уулзалтын өргөтгөсөн хуралдаанд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин, Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ нарын хамт оролцож, Монгол Улсын байр суурийг илэрхийлэн үг хэлсэн. Монгол Улс далайд гарцгүй орны хувьд газрын баялаг, бараа бүтээгдэхүүнээ бусад оронд дэлхийн зах зээлийн үнээр худалдах үүднээс ОХУ-ын Алс Дорнодын боомтуудыг ашиглан Монголын нүүрсийг экспортлох зорилгоор Монгол, Орос, Японы хамтарсан компани байгуулах саналыг дэвшүүлэв.

Чуулга уулзалтад оролцогчид Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилга нь Алс Дорнодод ложистикийн салбарыг илүү хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг тэмдэглэж, мөн Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөц бололцоог ашиглан Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээг байгуулах боломжтой зэрэг саналыг дэвшүүлсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын эдийн засгийн III чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулсан “Орос ба Монгол: Уулзах цэг – Алс Дорнод” сэдэвт бизнес чуулга уулзалтад оролцов. Хоёр орны 150 гаруй бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцсон уг арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ Монгол, Оросын уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхийн ач холбогдлыг онцолж, Монгол Улсын Тавантолгойн сайн чанарын нүүрсийг төмөр замаар дамжуулж борлуулах боломжтойг тэмдэглэсэн. Түүнчлэн Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн коридорыг байгуулах нь Алс Дорнодын бүс нутгийн хөгжил, дэд бүтцийн орчныг сайжруулахад чухал хувь нэмэр оруулна гэж үзэж буйгаа илэрхийлсэн юм.

Монгол, Оросын бизнес чуулга уулзалтын үеэр Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайд Б.Дэлгэрмаа, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, “УБТЗ” ХНН-ийн дарга Д.Жигжиднямаа, Оросын талаас Ерөнхийлөгчийн туслах И.Е.Левитин, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд И.К.Азизов, “Оросын төмөр замууд” ХНН-ийн Ерөнхийлөгч О.В.Белозеров зэрэг хүмүүс үг хэлэв.

Гурав. Хоёр талын бусад үулзалтууд: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын эдийн засгийн III чуулга уулзалтад оролцох үеэр БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин, Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ, Японы “JBIC” банкны Гүйцэтгэх захирал Тадаши Маэда нартай хоёр талын уулзалт хийсэн.

3.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 6 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чиндао хотноо болсон Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага /ШХАБ/-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн ээлжит 18 дугаар хуралдаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Дарга Ши Жиньпиний урилгаар оролцов. Энэ удаагийн хуралдаанаар 2017 оны

Астанад болсон дээд хэмжээний уулзалтын үеэр тохиролцсон ажлын биелэлт, дэлхийн улс төр, эдийн засагт гарч буй үйл явцтай холбогдуулан ШХАБ-ын цаашдын хөгжлийн тулгамдсан асуудлыг хэлэлцэв. Энэтхэг, Пакистан улсууд ШХАБ-д элссэнээр тус байгууллага онцгой, нөлөө, нэр хүнд бүхий бүс нутгийн байгууллага болж, хүчин чадал нь мэдэгдэхүйц өссөнийг болон ШХАБ-ын 2025 он хүртэлх хөгжлийн стратегид тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагыг тэмдэглэв.

ШХАБ-ын дээд түвшний уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч ШХАБ-ын гишүүн, оролцогч орнууд болон олон улсын байгууллагуудын төлөөлөгчдийн тэргүүн нарын өргөтгөсөн хуралдаанд оролцон үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ “Монгол Улс тус байгууллагын орнуудтай хамтран эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэр, хөдөө аж ахуй болон эдийн засгийн бусад салбар, мөн түүнчлэн хүмүүнлэгийн хамтын ажиллагаа, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, байгаль орчин, онцгой байдлын менежмент болон терроризм, мансууруулах бодисын хууль бус наймаатай тэмцэх зэрэг салбарт идэвхтэй хамтран ажиллахыг зорьж байгаа”-гаа дурдаад “Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад шат ахиулан оролцох боломжийг нарийвчлан судалж байгаа бөгөөд зохих хэлэлцүүлгийг улс төр, нийгмийн хүрээнд эхлүүлээд байна” хэмээн мэдэгдсэн.

Түүнчлэн Монголын “Хөгжлийн зам” хөтөлбөрийг Хятадын “Бүс ба зам” санаачилга болон Оросын “Евразийн эдийн засгийн холбоо” хамтын ажиллагааны механизмтай уялдуулах, Монгол Улсын нутаг дэвсгэрээр Монгол, Орос, Хятадын “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийг бодитойгоор хэрэгжүүлэх, үүний тулд гурван талын хамтарсан механизмыг боловсронгуй болгох, Монгол Улсын газар нутгаар дамжуулан төмөр зам, автозам, байгалийн хий, газрын тосны хоолой тавих, худалдааг хөнгөвчлөх, тарифын болон тарифын бус хориг саадыг арилгах, Монгол Улсыг Зүүн Азийн дээд түвшний уулзалтад нэгдэхэд ШХАБ-ын гишүүн орнууд, ялангуяа ОХУ, БНХАУ онцгой анхаарал тавьж, дэмжинэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн.

ШХАБ-ын дээд түвшний энэхүү уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, ОХУ-ын Ерөнхийлөгч, БНХАУ-ын дарга нарын гурван талт дээд түвшний ээлжит дөрөв дэх уулзалтыг хийж, гурван талын хамтын ажиллагааны цаашдын чиг хандлагын талаар ярилцав.

Өнгөрсөн хугацаанд гурван талын хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлсэн Дунд хугацааны замын зураглал, Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэдэгт санал нэгдэж, худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал, хил орчмын хамтын ажиллагааны талаар санал солилцож, эдгээр салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх эрмэлзлээ дахин нотлов.

Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан нэн тэргүүнд хэрэгжүүлэх төслүүдийг ажил хэрэг болгохын төлөө илүү их идэвх чармайлт гаргахыг монголын тал уриалж, уг хөтөлбөрт тусгагдсан төслүүдийн нарийвчилсан

судалгаа хийх, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах үүднээс Хөрөнгө оруулалтын судалгааны хамтарсан төвийг байгуулахыг яаравчлах шаардлагатай гэдэг байр сууриа илэрхийлсэн.

Хятадаас Европ руу чиглэсэн ачааны тээвэрлэлт үлэмж ихээр нэмэгдэж байгаатай холбогдуулан дамжин өнгөрөх тээврийн салбар нь гурван талт хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэхийг талууд онцлон тэмдэглэв. Энэ хүрээнд Монгол, Оросын хамтарсан “УБТЗ” ХНН-ийн төмөр зам болон залгаа бүсийн 2018 – 2020 онд хийх шинэчлэлд 260 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буйгаа оросын тал мэдэгдсэн юм.

Цаашид гурван улсын Тээврийн сайд нарын уулзалтыг зохион байгуулж, дэд бүтцийн төслүүдийг бодитоор хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой уг механизмыг тогтмолжуулах саналыг Монголын тал дэвшүүлж, Орос, Хятадын тал дэмжсэн.

Эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд Монголын талаас удаа дараа тавьж ирсэн Орос, Хятадыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх саналыг Орос, Хятадын талууд дэмжиж буйгаа илэрхийлж, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах шаардлагатайг онцлов.

ШХАБ-д Монгол Улс шат ахиулан оролцох бололцоог судалж буйтай холбогдуулан ШХАБ-ын хүрээнд уялдаа зохицуулалтаа өргөжүүлж, Монгол Улс тус байгууллагын бүрэн эрхт гишүүн болж, илүү гүнзгий оролцохыг БНХАУ-ын дарга Ши Жиньпин урив.

2019 онд болох гурван улсын төрийн тэргүүн нарын ээлжит уулзалтыг Бүгд Найрамдах Киргиз Улсад болох ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр зохион байгуулахаар тохиролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад харилцааны чиглэлээр авч хэрэгжүүлсэн бусад ажлуудын талаар:

3.1.3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дипломат корпусын төлөөлөгчийн газрын тэргүүн нарыг 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авч, мэндчилгээ дэвшүүлсэн.

3.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд, суурин төлөөлөгч, Монгол Улсад айлчилсан болон ажилласан гадаад улсын төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан талаар:

№	Улс, байгууллага, албан тушаал	Нэр
Гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд		
1	Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Жон Лантри
2	Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	хатагтай Женифер Зимдал Галт

3	Арабын Нэгдсэн Эмират Улсын Элчин сайд	Абдулла Абдулрахман Абдуллабин Рабияа Аль Тиниж
4	Бельгийн Вант Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Марк Винк
5	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Доан Тхи Хыён
6	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд	Жон Жэ Нам
7	Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Шин Хаймин
8	Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Ивана Гроллова
9	Бүгд Найрамдах Энэтхэг Улс Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Суреш Бабу
10	Буркино Фасо Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Антуан Сомда
11	Бүгд Найрамдах Австри Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Фридрих Штифт
12	Бүгд Найрамдах Азербайжан Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Рамзи Казимоглу Тэймуров
13	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	О Сын Хо
14	Бүгд Найрамдах Беларусь Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	С.Чепурной
15	Бүгд Найрамдах Итали Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Андрэа Де Фелип
16	Бүгд Найрамдах Казахстан Улсын Элчин сайд	Калыбек Кобландин
17	Бүгд Найрамдах Киргиз Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Азамат Усенов
18	Бүгд Найрамдах Кот д'Ивуар Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Адама Доссо
19	Бүгд Найрамдах Мали Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Тиефинг Конате
20	Бүгд Найрамдах Узбекистан Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Бахтиёр Саидов
21	Бүгд Найрамдах Филиппин Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Хосе Сантьяго Романа

22	Бүгд Найрамдах Финланд Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Ярно Сирияла
23	Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд	Элизабет Барсак
24	Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Иржи Бродский
25	Европын холбоо, түүний гишүүн Бельги, Финланд, Австри, Словак, Эстони, Грек, Литва, Унгар, ХБНГУ, Франц, Швед, Мальта, Латви, Словен, Чех, Итали, Болгар, ИБУИНВУ, Нидерланд, Люксембург, Испани, Дани зэрэг орноос Монгол Улсад суугаа	Элчин сайд нар
26	Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Траян Лауренцю Христееа
27	Европын холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд	Ханс Дийтмар Швайсгут
28	Израиль Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Ц.Хэйфец
29	Ирланд Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Оуэн О'Лири
30	Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Жанан Мосазай
31	Исланд Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Гуннар Снорри Гуннарсон
32	Испанийн Вант Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Алберто Карнеро Фернандээ
33	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Филип Мэлоун
34	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Кэтрин Арнолд
35	Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Эд Жэйгэр
36	Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Дэвид Спрул
37	Катар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Султан Салмиин Саид Аль-Мансури
38	Куба Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Штефан Дүппел
39	Куба Улсын Элчин сайд	Раул Дэлгадо Консэпсион

40	Кувейт Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд	Халед Аль Фадли
41	Люксембургийн Их Гүнт Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Марк Хубш
42	Мексикийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Бруно Фигуэроа Фишер
43	Румын Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Константинеску Василика
44	Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Ахмет Язал
45	Туркменстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд	Чинар Рустамова
46	Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Галошфаи Михай Матиаш
47	Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсаас Монгол Улсад хавсран суугаа Элчин сайд	Баба Ахмад Жида
48	Япон Улсын Элчин сайд	М.Такаока
Монгол Улсад айлчилсан болон ажилласан гадаад улсын төлөөлөгч		
49	Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын төлөөлөгчдийн танхимын Гадаад бодлогын байнгын хорооны Ази, номхон далайн дэд хорооны дарга, төлөөлөгчдийн танхимын гишүүн	Тэд Ёохо
50	Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын төлөөлөгчдийн танхимын гишүүн	Элизабет Эсти, Том Гарретт, Бүбен Кихүэн нар
51	Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департментын туслах ТНБД-ын үүрэг гүйцэтгэгч	Сюзан Торнтон
52	Арабын Нэгдсэн Эмират Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх	Шейх Султан Бин Халифа Аль Нахъяан
53	Балба улсын Гадаад хэргийн сайд	Прадип Кумар Гявал
54	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн зөвлөлийн гишүүн, Гадаад хэргийн сайд	Ван И
55	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Дотоод хэргийн сайд	Ражнат Сингх
56	Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Гадаад хэргийн сайд	Сушма Свараж
57	Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхий сайдын тусгай элч, ГХЯ-ны 3 дугаар улс төрийн газрын захирал	Улан Джусупов
58	Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд	Бинали Йылдырым
59	Ирланд Улсын парламентын доод танхимын дарга	Шон О'Фарел

60	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Монгол Улстай харилцах Худалдааны элч, Парламентын гишүүн	Жулиан Найт
61	Катар улсын Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Төрийн сайд	Солтан Бин Саад Ал-Мурайхи
62	ИБУИНВУ-ын Парламентын төлөөлөгчид	Лимпнигийн Эрхэмсэг ноён Лорд Ховард тэргүүтэй
63	Малайз улсын Шадар сайд	Дато Се Азаза Ван Исмайл
64	Оросын Холбооны Улсын Аж үйлдвэр, худалдааны сайд	Денис Валентинович Мантуров
65	Оросын Холбооны Улсын Буриадын Бүгд Найрамдах Улсын тэргүүн	Цыденов Алексей Самбуевич
66	Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува Улсын тэргүүн	Шолбан Валерьевич Кара-Оол
67	Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн дэд сайд	И.В.Моргулов
68	Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн бие төлөөлөгч	И.Е.Левитин
69	Оросын Холбооны Улсын Засгийн газрын орлогч дарга, Алс Дорнодын Холбооны тойрог дахь ОХУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхт төлөөлөгч	Ю.П.Трутнев
70	Оросын Холбооны Улсын Оросын төмөр замууд нээлттэй хувьцаат нийгэмлэгийн Ерөнхийлөгч	Олег Валентинович Белозёров
71	Оросын Холбооны Улсын Тээврийн сайд	Евгений Иванович Дитрих
72	Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн Амбан захирагч	Сергей Георгиевич Левченко
73	Саудын Арабын Вант Улсын Эрхэм дээд хунтайж	Абдула бин Абдулрахман бин Абдулазиз Аль-Сауд
74	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотын дарга	Михаель Мюллер
75	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн гишүүн	Манфред Грунд
76	Швейцарын Холбооны Улсын Гадаад хэргийн сайд	И.Кассис
77	Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга	Т.Оошима
78	Япон Улсын Шизүока мужийн Засаг дарга	Х.Кавакацү

79	Японы парламент дахь Япон, Монголын найрамдлын бүлгийн дарга	М.Хаяаши
80	Японы парламентын төлөөлөгчдийн танхимын гишүүн	Ясүхиса Шиозаки
81	Японы Хоккайдо-Монголын эдийн засгийн харилцааг дэмжих нийгэмлэгийн Тэргүүн, Саппоро дахь Өргөмжит консул	Такэбэ Цүтому
Монгол Улсад айлчилсан болон ажилласан гадаадын байгууллагын төлөөлөгч		
82	Ази, Номхон далайн бүс нутгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбооны ерөнхийлөгч	Ж.Инайшвили
83	Азийн сангийн Ерөнхийлөгч	Дэвид Д.Арнолд
84	ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал	Шин Ён Су
85	Европын сэргээн босголт хөгжлийн банкны Нидерланд, Монгол Улсыг төлөөлсөн захирал	Франс Вийкерс
86	Европын сэргээн босголт хөгжлийн банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч	Филип Беннетт
87	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн гүйцэтгэх захирал	Эрик Солхейм
88	Олон Улсын "Азийн хүүхдүүд" спортын наадмын хорооны Ерөнхийлөгч	Д.Е.Глушко
89	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Конрад Аденауэр сангийн Ерөнхий нарийн бичгийн орлогч	Герхард Валерс
90	Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга	Рашид Алимов
91	Япон-Монголын хамтарсан 10 дахь удаагийн олон улсын хуралд оролцохоор ирсэн доктор, профессорууд	
Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын байгууллагын төлөөлөгч		
92	Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч	Ёланда Фернандез Ломмэн
93	Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч	Жэймс Андерсон
94	ЖАЙКА-гийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын дарга	Мүцүми Сато
95	Конрад Аденауэрийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч	Даниэль Шмүкинг
96	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгч	Б Транкман
97	Нэгдсэн Үндэстний Байгууллагын ХХААБ-ын Суурин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэгч	Аднан Рауф Куэрэш

98	ОУВС-гийн Монгол Улсыг хариуцсан ажлын хэсгийн ахлагч	Коши Матай
99	Монгол Улсын соёлын элчээр гадаадад томилогдон ажиллаж байгаа	Соёлын зүтгэлтнүүд
100	Хилийн чанад дахь монголчуудын холбоо	Төлөөлөгчид

болон бусад гадаад улсын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

3.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах эрхийн хүрээнд:

3.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд холбогдох хуулийн заалтыг үндэслэн Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Энхсайхан, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Баяр нарыг эгүүлэн татаж, Шведийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Энхцэцэг, Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбадаржаагийн Батжаргал, Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ядмаагийн Ариунболд, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нархүүгийн Тулга нарыг тус тус томилохоор Улсын Их Хуралд зөвшилцөхөөр хүргүүлсэн.

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо уг асуудлыг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн дэмжсэн. УИХ-аас Монгол Улсаас Шведийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Энхсайхан, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Баяр нарыг эгүүлэн татах болон Элчин сайдад нэр дэвшигч Очирын Энхцэцэг, Дамбадаржаагийн Батжаргал, Ядмаагийн Ариунболд, Нархүүгийн Тулга нарыг томилохыг Улсын Их Хурал дэмжсэн болно.

3.3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах бүрэн эрхийн хүрээнд:

Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авлаа. Үүнд:

№	Огноо	Улс	Нэр
1.	2018/05/29	Европын Холбооноос Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Траян Лауренцю Христееа
2.	2018/05/17	Бүгд Найрамдах Солонгос Улсаас	Жон Жэ Нам

		Монгол Улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд	
3.	2018/04/04	Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Баба Ахмад Жида
4.	2018/04/04	Испанийн Вант Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Алберто Карнеро Фернандез
5.	2018/04/04	Исланд Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Гуннар Снорри Гуннарсон
6.	2018/04/04	Бүгд Найрамдах Узбекистан Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Бахтиёр Саидов
7.	2018/04/04	Румын Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Константинеску Василика
8.	2018/04/04	Ирланд Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Оуэн О'Лири
9.	2018/04/04	Люксембургийн Их Гүнт Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Марк Хубш
10.	2018/04/04	Бүгд Найрамдах Азербайжан Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Рамзи Казимоглу Тэймуров
11.	2018/04/04	Буркино Фасо Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Антуан Сомда
12.	2018/04/03	Бүгд Найрамдах Кот д'Ивуар Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Адама Доссо
13.	2018/04/03	Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Жанан Мосазай
14.	2018/04/03	Мексикийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Бруно Фигуэроа Фишер
15.	2018/04/03	Бүгд Найрамдах Мали Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин сайд	Тиефинг Конате
16.	2018/04/03	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Филип Мэлоун
17.	2018/01/08	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	О Сын Хо
18.	2017/11/01	Бүгд Найрамдах Филиппин Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Хосе Сантьяго Романа
19.	2017/11/01	Бүгд Найрамдах Киргиз Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Азамат Усенов
20.	2017/10/31	Бельгийн Вант Улсаас Монгол Улсад	Марк Винк

		суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	
21.	2017/10/31	Бүгд Найрамдах Финланд Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Ярно Сиряла
22.	2017/10/31	Бүгд Найрамдах Австри Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Фридрих Штифт
23.	2017/10/03	Унгар Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Галошфаи Михай Матиаш
24.	2017/09/22	Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Иржи Бродский
25.	2017/09/18	Канад Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Дэвид Спрул
26.	2017/08/18	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд	Доан Тхи Хыёнг

ДӨРӨВ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН БУСАД АСУУДЛААР

4.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилласан талаар:

4.1.1. Хууль тогтоомжид заасны дагуу улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах, хүртээсэн цол, шагнасан одон, медалийг хасах бүрэн эрхийн хүрээнд:

1. 2017 оны 7 дугаар сарын 10-наас 2018 оны 7 дугаар сарын 10-ны хооронд Монголын Тулгар төр, Их Монгол Улс, Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгалын ой, аймаг, сумд, байгууллагуудын тэгш ойг тохиолдуулан Монгол Улсын цол, одон медалиар шагнуулахаар 42556 иргэн, 51 байгууллагыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус өргөн мэдүүлсэн. Эдгээрийг судлан үзээд 21 байгууллага, 14353 иргэнийг төрийн дээд цол одон медалиар, 637 албан хаагчийг энхийн төлөө медалиар, 8636 эхийг Алдарт эхийн I, II одонгоор шагнасан байна.

2. Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн “Чингис хаан” одон бий болгох тухай 21 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын 2012 оны 56 дугаар тогтоолоор “Чингис хаан” одонг Их эзэн Чингис хааны мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгож байхаар тогтсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2017 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн 60 дугаар зарлиг гаргаж, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Найдангийн Түвшинбаярыг Монгол Улсаас спортын их наадам зуны олимпын анхны аварга, хос медальтан болж, улс үндэстнийхээ өмнө бахархам, онцгой гавьяа

байгуулсныг нь үнэлж, Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн одон - "Чингис хаан" одонгоор шагнасан.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 79 дүгээр зарлигаар Монголын их түүхийн тухай "Монголчууд", "Тусгаар тогтнолын түүх" цуврал сонсдог номыг түүх судалгааны үнэн байх зарчимд тулгуурлан бүтээж, монголчуудын оюуны санд залуу хойч үеийнхний түүхийн боловсролыг дээшлүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх түүхээ сурталчлан таниулах, түгээх зэрэг их хувь нэмэр оруулсныг нь үнэлж, түүхч Дэмбэрэлийн Өлзийбаатар, Монголын эзэнт гүрний байлдан дагууллын мөрөөр сүүлийн 15 жилийн хугацаанд 30 гаруй улсын 300 гаруй хот сууринд монгол судлалын чиглэлээр судалгаа хийн Ил хаадын үеийн хосгүй үнэт, ховор дурсгалуудаас 5 төрлийн 57 нэрийн 200 гаруй дурсгалыг сонгон "Ил хаадын урлаг, соёлын бүтээлүүд" судалгааны бүтээлийг перс, англи, монгол хэл, бичгээр хэвлүүлж, Монгол Улсын их түүх, соёлыг дэлхий дахинаар сурталчлан таниулахад оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, "Тархан суурьшсан монголчууд" ТББ-ын тэргүүн, соёл судлаач Цэрэндоржийн Санчир нарт Монгол Улсын Төрийн шагнал хүртээсэн.

4. Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1-ийн 7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах, хүртээсэн цол, шагнасан одон, медалийг хасах бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ 3 удаагийн зарлигаар 6 хүний цэргийн дээд цол, улсын цолыг хассан. Үүнд:

- Цэргийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн болон Монгол Улсын харьяатаас гарсан цэргийн алба хаагчийн цэргийн цолыг цол олгосон албан тушаалтны шийдвэрээр хурааж авна" гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 33 дугаар зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан иргэний дээд офицерын "Бригадын генерал" цолыг, 4 дүгээр сарын 23-ны өдрийн 42 дугаар зарлигаар гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон 2 иргэний дээд офицерын "Хошууч генерал", 1 иргэний "Бригадын генерал" цолыг тус тус хассан.
- Монгол Улсын Үндсэн хууль болон Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 44 дүгээр зарлигаар Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, зөвшөөрөлгүйгээр, төрийн байгууллагын тодорхой чиглэл, мэдэгдлийг үл хайхарч, хүүхдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулсан болон бусад шалтгааныг үл хайхран "Дүнжингарав-2018" морин уралдааныг зохион байгуулсан Морин спорт, уяачдын холбооны удирдлагуудын "Улсын тод манлай уяач", "Улсын алдарт уяач" цолыг тус тус хассан.

4.1.2. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д зааснаар уучлал үзүүлэх бүрэн эрхийн хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан уучлал үзүүлэхийг хүссэн нийт 62 өргөдлийг хүлээн авч, хянан үзээд өргөдлийн шаардлага хангаагүй 21 өргөдлийг буцааж, бусад 41 өргөдлийг судалж байна.

4.1.3. Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх бүрэн эрхийн хүрээнд:

Монгол Улсын харьяат болох хүсэлт 17, Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт 561, Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох 104 хүсэлт тус тус хүлээн авч судлан үзээд, Монгол Улсын иргэний харьяатаас гаргах тухай зарлигаар 543 иргэний хүсэлтийг, Монгол Улсын харьяат болгох тухай зарлигаар 3 хүний хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн. Бусад хүсэлтийг судалж байна.

4.2. Монгол Улсын Ерөнхийлөгчид Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиас гадна бусад хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилласан талаар:

4.2.1. Монгол хэлний тухай хуулийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд монгол хэлийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн үүрэг бүхий Хэлний бодлогын үндэсний зөвлөл ажиллаж байна.

1. Монгол хэлний тухай хуулийн 21.2-т Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн гишүүдийг монгол хэл, утга зохиолын эрдэмтэн, хэвлэл мэдээлэл, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын мэргэжлийн төлөөллөөс сонгож 6 жилийн хугацаатай томилохоор заасан Монгол хэлний тухай хуулийн шаардлагыг хангуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 51 дүгээр зарлигаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийг шинэчлэн байгуулсан.

2. Иргэд, олон нийтийн дунд монгол хэлний зөв бичих дүрэм өөрчлөгдсөн мэт төөрөгдөл, олон янзаар бичиж хэвшсэн үгсийн асуудлыг шийдвэрлэх үүднээс Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 05 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толийг 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцэн, 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталж, улс орон даяар бүх нийтээр дагаж мөрдөхөөр журамлав.

Монгол хэлний журамласан толийн нээлтийг 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга оролцон “Өнөөдрөөс эхлээд Монгол Улсын нийт иргэд, төрийн албан хаагчид, эрдэмтэд, судлаачид, хэвлэлийн газрынхан, сонины редакцынхан энэ толийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, баримтлах учиртай. Төрөөс монгол хэлний зөв бичих дүрмийг албан ёсоор журамлаж байна гэж үзээд энэ толийг мөрдлөг болгох нь өнөөгийн шаардлагад нийцнэ. “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” бол хэлний хэрэглээний хувьд үндсэн хууль адил заавал дагаж мөрдөх баримт хэрэглэгдэхүүн юм” хэмээсэн юм.

Аймаг, нийслэлийн дүүргүүдэд байгуулагдсан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлтэй хамтран 7600 багшийг хамруулсан Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, мэргэжил аргагүйн талаар сургалтыг зохион байгуулж, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумын сургууль болон төрийн байгууллагад толь бичгийг тарааж, цахим хувилбаруудыг нийтийн хүртээл болгов.

3. Монгол хэлний тухай хуулийн 13.1.1-д заасны дагуу монгол бичгийн урт болон дунд хугацааны хөтөлбөрт 21 аймгийн багш нараас санал авч нэгтгэн, хөтөлбөрийн төслийг харьяа яам болон Боловсролын хүрээлэнд хүргүүлэв.

4. 2017-2018 онд Хэлний салбар зөвлөлөөр дамжуулан Монгол хэлний хуулийн 17.1.2-т заасан хаягжилтын талаар судалгаа хийн, хуулийн дагуу хяналт тавьж, үүрэг чиглэл өгөв. Судалгаанаас харахад хуулийн дээрх заалтын хэрэгжилт Нийслэлд 20, Архангай 50, Баянхонгор 60, Баян-Өлгий 20, Булган 65, Говь-Алтай 30, Говьсүмбэр 20, Дархан-Уул 30, Дорнод 50, Дорноговь 40, Дундговь 30, Завхан 80, Орхон 60, Өвөрхангай 20, Өмнөговь 50, Сэлэнгэ 20, Сүхбаатар 30, Төв 60, Увс 60, Хэнтий 70, Ховд 50, Хөвсгөл 30 хувьтай байна.

5. Монгол хэлний тухай хуулийн 22.2.5-д заасны дагуу төрийн албанд анх орох иргэнээс болон гадаадын иргэнээс авах монгол хэлний түвшин тогтоох шалгалтын агуулгыг боловсруулан ирүүлснийг хуульд зааснаар ХБҮЗ-ийн хурлаар хэлэлцэн баталж, Төрийн албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад бэлтгэх 2017 оны гарын авлагын 692-799 талд хэвлүүлсэн. Төрийн албаны зөвлөлөөс уг сорилгын дагуу 2017 оны 9 дүгээр сараас эхлэн шалгалт авч эхэлсэн.

4.2.2. Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т заасны дагуу билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн - Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан 100 болон түүнээс дээш настай ахмад настнуудад Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээ, гарын бэлэг гардуулахаар заасны дагуу 17 дугаар жарны шар нохой жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрийг тохиолдуулан нийт 121 ахмад настанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарын бэлэг, мэндчилгээг хүргүүлэв.

4.2.3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дипломат албаны тухай хуульд “Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч ... олгоно” гэж заасныг үндэслэн Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 811 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жил, Ардын хувьсгалын 96 жил, Ардчилсан хувьсгалын 28 жил, Монгол Улсад орчин цагийн дипломат алба үүсэж хөгжсөний 106 жилийн ойг тус тус тохиолдуулан 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 92 дугаар зарлиг гаргаж, Гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллан, гадаад бодлогын тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж байсан Балдоржийн Даваадорж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Жамбалдорж, Гадаад харилцааны яамны хөрш орнуудын газрын захирал Түвдэндоржийн Жанабазар нарт “Онц бөгөөд Бүрэн эрхт

Элчин сайд” цол, Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсын Станбул хотод суугаа Ерөнхий консул Энэбишийн Мөнх-Очирт “Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин” цол тус тус хүртээв.

4.2.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 181 дүгээр зарлигаар Төрийн тахилгатай уул хайрхны тэнгэрийг тайх төрийн ёслол үйлдэх хуваарь (2013-2032 он)-ийг баталсан. Энэхүү хуваарийн дагуу тахилгыг 5 жилд нэг удаа үйлдэж байхаар тогтоосон бөгөөд Хан Хөхий /Увс аймаг/ хайрхны тэнгэрийг тайх ёслолыг 2017 оны 7 дугаар сарын 28-ны өдөр, Их тахилгат /Өмнөговь аймаг/ хайрхны тэнгэрийг тайх ёслолыг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр, Алтан Хөхий хайрхны тэнгэрийг тайх ёслолыг 2018 оны 7 дугаар сарын 06-ны өдөр тус тус үйлдэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 85 дугаар зарлигаар батлагдсан “Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журам”-ын 2.2 дахь хэсэгт заасны дагуу Тахилгын ёслолд оролцох төрийн элч төлөөлөгчдийн тэргүүнээр Хан Хөхий хайрхны тэнгэрийг тайх ёслолд УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Их тахилгат хайрхны тэнгэрийг тайх ёслолд УИХ-ын гишүүн Л.Энхболд, Алтан Хөхий хайрхны тэнгэрийг тайх ёслолд УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж нар тус тус томилогдон оролцсон.

4.2.5. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Улсын баяр наадмыг Монгол Улсын Ерөнхийлөгч нээнэ”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Улсын баяр наадмыг хааж Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлнэ” гэж заасан.


Монгол Улсын Ерөнхийлөгч Монголын Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улсын 811 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жил, Ардын хувьсгалын 96 жил, Ардчилсан хувьсгалын 27 жилийн ой - Үндэсний их баяр наадмыг нээн мэндчилгээ дэвшүүлж, нийт ард иргэд, наадамчин олондоо хандан хэлсэн үгэндээ “Монголын сайн нэрийг өндөрт өргөж яваа хүн бүрийн халуун сэтгэл, хөдөлмөр зүтгэл өөрсдөө өөрсдөдөө эзэн байх их ухаан дээр эх орон минь өөдлөн дэвжиж явна. Тусгаар тогтнол минь бат, туг сүлд минь цэх байна. Хөдөлмөрч, хичээнгүй Монгол ялж, хөгжил дэвшлийн их замд тэмүүлж байна. Баяр наадмын энэ өдөр ч гэсэн бид хийж хэрэгжүүлэхээр зорьж буй олон ажлаа санаж, төлөвлөж, ярьж хэлж байх ёстой гэж би бодож байна. Улс орон, ард иргэдийн маань өмнө тулгамдсан ажилгүйдэл ядуурал, иргэдийн амьжиргааг улам бүр дордуулахад нэрмээс болж байгаа зарим өрийн асуудлыг шийдэхэд анхаарлаа хандуулж байна. Мөн эдийн засгаа сэргээн тогтворжуулах, бүтээн байгуулалтын их ажлаа цаг алдалгүй өрнүүлэх том зорилт бидний өмнө байгааг наадмын энэ индрээс би зориуд дурдаж байгаа юм. Монгол хэмээх нэгэн нэрийг ертөнцийн чихнээ дуурьсгаж буй монгол наадам маань бидний нэгэн чухал өв соёл билээ. Төрт ёсны их уламжлал, түүх соёлын гайхамшиг, түмэн олны сэтгэлийн цэнгэл хосолсон үндэсний их баяр наадам маань дэлгэр зуны сайн цагт ийнхүү эхэлж байна. Эх түүх, хэл соёлоороо бахархан омогшдог монгол хүн бүрийн сэтгэлд нар гийсэн наадмын сайхан өдөр зон олны минь сэтгэл тэнүүн цог золбоо дүүрэн морь нь хурдан, бөх нь хүчтэй, харваач нь мэргэн байг ээ. Дэлхийд ганцхан монгол наадам дэнж дүүргэн эхэлж байгааг

даяар олноо дуурьсган зарлая. Сайхан наадаарай. Туурга тусгаар улс орон минь хөгжин бадраг. Түмэн олон минь амар амгалан жаргаг” хэмээсэн юм.

4.2.6. Боловсролын тухай хуулийн 43.2.9-д “сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох”-оор заасныг үндэслэн, Засгийн газрын 2014 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилдэг оюутанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 2017 оны тэтгэлгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 62 дугаар зарлигаар нэр бүхий 30 оюутанд хүртээв.


4.2.7. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газарт 2017.07.10-2018.07.10-ны өдрийн хооронд иргэдээс нийт 1887 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч судлахад 474 буюу 25,1 хувь нь бүрэн эрхэд хамаарах шагнал, уучлал, иргэний харьяаллын асуудлаар; 1413 буюу 74,9 хувь нь бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар (орон сууц хүссэн, мөнгөн тусламж, санхүүгийн дэмжлэг хүссэн, тэтгэвэр тэтгэмжийн асуудлаар, эмчилгээ сувилгааны зардал хүссэн г.м) тус тус хандсан байна.

Зураг 03



Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн 474 өргөдөл, гомдлын 384 буюу 81 хувь нь шагналтай холбоотой, 50 буюу 10.5 хувь нь уучлал үзүүлэхийг хүссэн, 40 буюу 8.5 хувь нь иргэний харьяаллын асуудалтай холбоотой байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдол



Ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилж үзвэл өргөдөл, гомдол 1673 буюу 88.6 хувь, санал 214 буюу 11.3 хувь, бусад буюу /мэдээлэл, шаардлага, илтгэл/ зэрэг 89 буюу 0.4 хувь эзэлж байна.

4.2.8. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 7 дугаар сарын 10-наас 2018 оны 7 дугаар сарын 10-ны хооронд хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг, баяр ёслол, иргэдтэй хийсэн уулзалт дээр болон ард түмэндээ хандан нийт 93 удаа үг хэлэв.

Д/д	Огноо	Арга хэмжээ
1	2017/07/10	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөж, ард түмэндээ хандан анх удаа үг хэлэв.
2	2017/07/11	Үндэсний Их баяр наадмыг нээж, үг хэлэв.
3	2017/07/11	Төрийн дайллагад үг хэлэв.
4	2017/07/12	Үндэсний Их баяр наадмыг хааж, үг хэлэв.
5	2017/07/21	Цэргийн ёслолын жагсаалын бие бүрэлдэхүүнд хандан үг хэлэв.
6	2017/07/23	"Хааны эрэлд-2017" энхийг дэмжих ажиллагааг нээж, үг хэлэв.
7	2017/09/01	Хичээлийн шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлж, үг хэлэв.
8	2017/09/07	Дорнын эдийн засгийн III чуулга уулзалтад оролцож, үг хэлэв.
9	2017/09/10	Улс төрийн хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүл, төрөл төрөгсдөөс төрийн нэрийн өмнөөс уучлал хүсэж, үг хэлэв.
10	2017/09/12	Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын чуулганд оролцож, үг хэлэв.
11	2017/10/02	2017 оны УИХ-ын намрын чуулганы нээлтэд оролцож, үг хэлэв.
12	2017/10/16	"Бага дунд боловсролын удирдлагын шинэчлэл" олон улсын чуулганд оролцож, үг хэлэв.
13	2017/10/23	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний чуулганд оролцож, үг хэлэв.

14	2017/10/25	Олон улсын Монгол судлалын холбооны 30 жилийн ойн арга хэмжээнд оролцож, үг хэлэв.
15	2017/10/26	"Аж үйлдвэрээ аварч ажлын байраа баталгаажуулъя" сэдэвт уулзалтад оролцон үг хэлэв.
16	2017/11/01	Үндэсний шигшээ багийн тамирчин Д.Сумъяад Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Г.Одбаярт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээж, үг хэлэв.
17	2017/11/09	УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд биечлэн оролцож, гишүүдэд хандан үг хэлж, байр сууриа илэрхийлэв.
18	2017/11/15	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан "Оёдлын салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, гарц, шийдэл" зөвлөгөөнийг нээж, үг хэлэв.
19	2017/11/17	Их эзэн Чингис хааны мэндэлсний 855 жилийн ой - Монгол бахархлын өдөрт зориулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар уламжлал болгон зохиосон "Мөнх тэнгэрийн бичиг-2017" монгол бичгийн уран бичлэгийн үзэсгэлэнгийн нээлтэд оролцож, үг хэлэв.
20	2017/11/19	Чингис хаан одонг Н.Түвшинбаярт гардуулж, үг хэлэв.
21	2017/11/24	"Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах төрийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах, олон нийтийн оролцоо, хяналт" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэгт оролцож, үг хэлэв.
22	2017/11/29	"Улсын хөгжил, төрийн бодлогод эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлье" нээлттэй хэлэлцүүлэгт оролцож, үг хэлэв.
23	2017/11/30	Монголын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбооны 25 жилийн ойн баярын арга хэмжээнд оролцож, үг хэлэв.
24	2017/11/30	"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал" хэлэлцүүлэгт оролцож, үг хэлэв.
25	2017/12/08	"Авлига бол байгалийн давагдашгүй хүчин зүйл биш" сэдэвт зөвлөгөөнд оролцож, үг хэлэв.
26	2017/12/08	Түүхч Дэмбэрэлийн Өлзийбаатар, соёл судлаач Цэрэндоржийн Санчир нарт Монгол Улсын Төрийн шагнал хүртээж, үг хэлэв.
27	2017/12/08	Улаанбаатар их сургуулийн 25 жилийн ойн ёслолын нээлтэд оролцож, үг хэлэв.
28	2017/12/16	Монгол Улсад орчин үеийн дүрслэх урлаг үүсэж хөгжсөний 75 жилийн ойг тохиолдуулан Монголын Урчуудын Эвлэлийг Сүхбаатарын одонгоор шагнаж, үг хэлэв.
29	2017/12/26	Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жилийн ойд зориулан, УИХ-ын чуулганы хуралдааны танхимаас ард түмэндээ хандан үг хэлэв.
30	2017/12/29	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цомын төлөөх чансаа өндөр, шигшмэл 128 бөхийн барилдааныг нээж, үг хэлэв.

31	2017/12/31	Бүх ард түмэндээ хандан шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэв.
32	2018/01/05	УИХ-ын чуулганы хуралдаанд оролцож, үг хэлэв.
33	2018/01/11	Дипломат корпусын ахлагч, элчин сайд, суурин төлөөлөгчдөд хандан 17 дугаар жарны шар нохой жилийн цагаан сарын баярын мэндийг угтуулан дэвшүүлж, үг хэлэв.
34	2018/01/12	Монгол Улсад самбо бөхийн спорт үүсэж хөгжсөний 50 жилийн ой, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 49 дэх тэмцээний нээлтэд оролцож, үг хэлэв.
35	2018/01/14	Чингэлтэй дүүргийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
36	2018/01/15	Сүхбаатар дүүргийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
37	2018/01/19	Монгол Улсын генералуудтай уулзаж, үг хэлэв.
38	2018/01/20	Сонгинохайрхан дүүргийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
39	2018/01/20	Баянгол дүүргийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
40	2018/01/21	Хан-Уул, Баянзүрх, Багахангай, дүүргийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
41	2018/01/24	Хэнтий аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
42	2018/01/25	Дорнод аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
43	2018/01/26	Сүхбаатар аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
44	2018/01/27	Дорноговь аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
45	2018/01/29	Говьсүмбэр аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
46	2018/02/02	Прокурорын байгууллагын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнд оролцож, үг хэлэв.
47	2018/02/02	Монголд үйлдвэрлэсэн цахилгаан автобусыг нутгийн удирдлагуудад хүлээлгэж өгөх үйл ажиллагаанд оролцож, үг хэлэв.
48	2018/02/03	Өмнөговь аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
49	2018/02/05	Дундговь аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
50	2018/02/09	УИХ-ын намрын чуулганы хаалтын хуралдаанд оролцож, үг хэлэв.
51	2018/02/10	Орхон аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
52	2018/02/11	Хөвсгөл аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
53	2018/02/12	Булган аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
54	2018/02/14	Монголын уламжлалт сар шинийн баяр цагаан сарыг тохиолдуулан Монгол Улсын баатар цол, ардын болон гавьяат цол, төрийн одон медаль хүртээж, үг хэлэв.
55	2018/02/15	Уяачдад улсын цол хүртээж, үг хэлэв.
56	2018/02/16	Төрийн есөн хөлт цагаан тугт хүндэтгэл үзүүлж, ард түмэндээ Сар шинийн мэнд хүргэн үг хэлэв.
57	2018/02/21	Сэлэнгэ аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
58	2018/02/21	Дархан-Уул аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
59	2018/02/23	Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдтэй уулзаж, үг хэлэв.

60	2018/03/01	Зарим иргэдийг төрийн дээд цол, одон медалиар шагнаж үг хэлэв.
61	2018/03/17	Багануур, Налайх дүүргийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
62	2018/03/19	Төв аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
62	2018/03/20	Архангай аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
63	2018/03/21	Завхан аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
64	2018/03/22	Говь-Алтай аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
65	2018/03/22	Баянхонгор аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
66	2018/03/28	Монголын эдийн засгийн форумд оролцож, үг хэлэв.
67	2018/04/05	УИХ-ын хаврын чуулганы нээлтийн хуралдаанд оролцож, үг хэлэв.
68	2018/04/06	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, "Хөгжил ардчилал" ТББ болон Конрад-Аденауэр сангийн хамтран зохион байгуулсан "Баялгийн засаглал" цуврал хэлэлцүүлгийг нээж, үг хэлэв.
69	2018/04/06	Орон нутгийн 100 сэтгүүлчийн "Иргэний мэдэх эрх" уулзалтад оролцож, үг хэлэв.
70	2018/04/20	"Иргэн төсөл"-ийн үндэсний шалгаруулалт буюу Улаанбаатар хот болон орон нутгаас төсөлд оролцож байгаа багуудын хооронд болсон эцсийн шалгаруулалтыг нээж, үг хэлэв.
71	2018/04/27	Монголын генералуудын өдөрт зориулан Төрийн ёслол хүндэтгэлийн танхимд генералуудыг хүлээн авч уулзаад, нийт генералуудад хандаж, үг хэлэв.
72	2018/05/06	Баян-Өлгий аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
73	2018/05/07	Увс аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв.
74	2018/05/09	"Спорт ба Эрүүл монгол үндэстэн" хэлэлцүүлэгт оролцож, үг хэлэв.
75	2018/05/11	Самбо бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний нээлтийн ёслолд оролцож, үг хэлэв.
76	2018/05/17	Малчдын улсын зөвлөгөөнийг нээж, үг хэлэв.
77	2018/05/22	Монголын эдийн засгийн форумын үндсэн чуулганыг нээж, үг хэлэв.
78	2018/05/25	Төрийн тусгай хамгаалалтын газрыг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж, үг хэлэв.
79	2018/05/26	Өвөрхангай аймгийн иргэдтэй уулзаж, үг хэлэв
80	2018/05/27	Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэдтэй уулзаж, үг хэлэв.
81	2018/06/01	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан үг хэлэв.
82	2018/06/07	Монгол-Оросын эдийн засгийн чуулга уулзалтыг нээж, үг хэлэв.
83	2018/06/09	Зүүн Азийн жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээнийг нээж, үг хэлэв.
84	2018/06/09	Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын дөрөв дэх удаагийн дээд хэмжээний уулзалтад оролцож, үг хэлэв.

85	2018/06/10	ШХАБ-ын өргөтгөсөн хуралдаанд оролцож, үг хэлэв.
86	2018/06/14	ШЕЗ-ийн 25 жилийн ойг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлж, үг хэлэв.
87	2018/06/14	"Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны хамтарсан сургуулийн нээлтэд оролцож, үг хэлэв.
88	2018/06/19	"Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь" номын нээлтийн ёслолд оролцож, үг хэлэв.
89	2018/06/20	Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн 88 дахь удаагийн төгсөлтийн ёслолд оролцож, үг хэлэв
90	2018/06/23	"Эрхтэн шилжүүлэн суулгасан иргэдийн спортын тоглолт"-ыг нээж, үг хэлэв
91	2018/06/28	УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож, үг хэлэв
92	2018/07/09	Төрийн дээд цол, одон, медалиар шагнаж, үг хэлэв.
93	2018/07/10	Төрийн далбааны өдөрт зориулсан цэргийн ёслолын жагсаалын нээлтэд оролцож, үг хэлэв.

4.2.9. Монгол Улсын Их Хурал 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр шинэчлэн найруулсан Прокурорын тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Прокурорын тухай хууль мөрдөгдөж эхэлснээр өмнө мөрдөгдөж байсан Прокурорын байгууллагын тухай хууль хүчингүй болж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдан мөрдөгдөж байгаа Прокурорын байгууллагын үйл ажиллагааны зарим журмуудад өөрчлөлт оруулан шинэчлэх, холбогдох зарим журмыг шинээр батлах хууль зүйн шаардлага үүссэн бөгөөд энэ хүрээнд 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 7, 8, 9, 10, 11, 12 дугаар зарлигаар

1. Прокурорын тангараг өргөх ёслолын журам;
2. Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журам;
3. Прокурорын байгууллагын бэлгэдлийн загвар, түүнийг хэрэглэх журам;
4. Прокурорын байгууллагын далбааны загвар, түүнийг хэрэглэх журам;
5. Прокурорын дүрэмт хувцас хэрэглэх журам;
6. Прокурорын энгэрийн тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журам;
7. Прокурорын ёс зүйн дүрэм;
8. Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам;
9. Прокурорын мэргэжлийн дүрэм;
10. Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам;
11. Прокурорын сахилгын дүрмийг тус тус шинэчлэн батлав.

4.2.10. 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Шүүгчийн сонгон шалгаруулалтын журам нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зарим зохицуулалт нь хуулиас давсан байсан тул Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн сонгон шалгаруулалтыг энэхүү журмаар зохион байгуулж чадахгүй нөхцөл байдал үүссэн байсан тул журмыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн, шүүгчийн

сонгон шалгаруулалтыг хүнд сурталгүй, ил тод, шударга байх зарчмыг баримтлан дахин боловсруулж батлуулав.

“Шүүгч нь хараат бус байж гагцхүү хуульд захирагдана” гэсэн Үндсэн хуулийн зарчим алдагдаж, шударга шүүхийн тогтолцоо үгүй болсон, шүүгч нар шударга ёс тогтоох үндсэн чиг үүргээ хангалтгүй биелүүлдэг, бодит орлогоосоо давсан хөрөнгөтэй, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байх магадлалтай талаар Монгол Улсын Их Хурлын зарим гишүүдийн хийсэн мэдэгдэл, ярилцлага, шүүмжлэлээс үүдэн Шүүх байгууллагын нэр хүнд олон нийтэд унаж байна.

Иймд 2018 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн Е/05 тоот албан бичгээр өөрийн эрхлэх чиг үүргийнхээ хүрээнд шүүгч нарын орлого хэрхэн өөрчлөгдсөн талаар судлан хянаж, бодит орлогоосоо давсан хөрөнгө, орлоготой хүнийг хянан шалгах ажлыг яаралтай зохион байгуулж хариу мэдэгдэхийг Авлигатай тэмцэх газрын даргад үүрэг болгосон.

4.2.11. Монгол Улсын Ерөнхийлөгч Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр 14 тоот захирамж гаргаж, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн 15 гишүүнийг 4 жилийн хугацаагаар томилсон.

Мөн Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 30 дугаар зарлигаар Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн ажиллах журмыг баталсан.

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга 2017-2021 онд хэрэгжүүлэх Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрөө 2017 оны 97 дугаар зарлигаар баталсан.

Энэхүү хөтөлбөр нь “Эв нэгдлийг эрхэмлэж, үндэсний эрх ашгаа дээдэлсэн Эх оронч Ерөнхийлөгч байна; Эрх чөлөө, шударга ёсыг сахин хамгаалж, иргэнээ дээдэлсэн Эх оронч Ерөнхийлөгч байна; Эдийн засгаа сэргээж, аж үйлдвэрийг хөгжүүлсэн Эх оронч Ерөнхийлөгч байна; Экологийн тэнцвэрийг хангаж, газар нутгаа хамгаалсан Эх оронч Ерөнхийлөгч байна; Экспортын шинэ эринийг эхлүүлсэн, эрх тэгш гадаад харилцааг хөгжүүлэгч Эх оронч Ерөнхийлөгч байна” гэсэн үндсэн таван зорилттой.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа зарим ажлын явцын талаар тоймлон танилцуулбал:

1. Эв нэгдлийг эрхэмлэж, үндэсний эрх ашгаа дээдэлсэн Эх оронч Ерөнхийлөгч байна:

1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн “Даяаршил, технологийн хурдацтай хөгжлийн эрин үед үндэснийхээ түүхэн уламжлал, хэл, соёлын дархлааг хамгаалах” заалтын хүрээнд монгол судлалыг ивээлдээ авч, эх хэл, үндэсний бичиг, уламжлалт соёлдоо анхааран ажиллаж байна.

1. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдөр “Эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлиг гаргаж, жил бүрийн 9 дүгээр сарын 01-ний өдрийг “Эх хэлний өдөр” болгон зарласан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хэлний бодлогын үндэсний зөвлөл хамтран “Эх хэлний тулгамдсан асуудал, хэтийн төлөв” хэлэлцүүлгийг зохион байгуулсан /2017.10.17/.

2. “Буддын мэдлэг ухаан ба орчин үеийн шинжлэх ухаан” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулав /2017.10.13/.

3. Их эзэн Чингис хааны мэндэлсний 855 жилийн ой-Монгол бахархлын өдөрт зориулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар уламжлал болгон “Мөнх тэнгэрийн бичиг-2017” монгол бичгийн уран бичлэгийн үзэсгэлэнг сурагчдын бүтээлээр толилуулсан /2017.11.17/.

4. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдөр “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 46 дугаар зарлиг гаргаж, зарим байгууллагуудад үүрэг чиглэл өгсөн. Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд Ерөнхий сайдын захирамж, БСШУС-ын сайдын болон холбогдох бусад газрын даргын тушаал шийдвэр гарч, ажлын хэсэг байгуулагдан, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017-2021 онд хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны хөтөлбөрийн соёл, шашны бодлогын хүрээнд “Ардыг тэжээх рашааны дусал” нэвтрүүлгийг бэлтгэн, хоёр долоо хоног тутамд олон нийтийн хүртээл болгож байна.

1.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар эерэг хандлага, хөгжлийг нийгэмд төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилготой “Эерэг хандлага, хөгжил” аяныг эхлүүлж, улс орон даяар нийт оюутан залуус, хүүхэд багачуудын хандлага, төлөвшил, хүмүүжлийн асуудалд чиглэсэн сургалт-лекцийг зохион байгуулж байна /2018.4.30/.

1.3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрөөр улс төрийн хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүл, төрөл төрөгсдөөс өнөөдөр төрийн нэрийн өмнөөс уучлал хүсэв.

1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Улсын хөгжил, төрийн бодлогод эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлье” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг

Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд болж, эрдэмтэд байр сууриа илэрхийлэн, Ерөнхийлөгчийн санаачилгуудыг дэмжиж байгаагаа илэрхийлэв /2017.11.29/.

2. Эрх чөлөө, шударга сыг сахин хамгаалж, иргэнээ дээдэлсэн Эх оронч Ерөнхийлөгч байна.

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон Ерөнхийлөгчийн Бодлого үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 01 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн нийт 22000 гаруй иргэдтэй иргэдтэй биечлэн уулзаж, иргэдийн санал бодол, хүсэлтийг нээлттэй сонсож, санал солилцон, тодорхой асуултуудад хариулт өгч ажиллалаа.

Иргэдээс гарсан санал, захидал, өргөдлийн талаар:

Аймаг, нийслэлийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр 3165 иргэн өөрийн санал, хүсэлтээ илэрхийлснээс 1360 иргэн биечлэн /уулзалтын үед микрофон дээр хэлсэн/ илэрхийлсэн бол 1805 иргэн захидал, өргөдөл болон бичгээр ирүүлжээ. Санал, хүсэлтийг аймаг, дүүрэг тус бүрээр авч үзвэл:

Зураг 05



Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 22200 иргэдтэй биечлэн уулзсан

д/д	Дүүрэг	Уулзалт хийсэн	Уулзалтад оролцсон	Уулзалтын үеэр санал, хүсэлтээ илэрхийлсэн иргэд
-----	--------	----------------	--------------------	--

		огноо	иргэдийн тоо	Биечлэн илэрхийлсэн /микрофон дээр хэлсэн/	Бичгээр илэрхийлсэн	Нийт
1	Чингэлтэй	2018.01.14	1000	66	65	131
2	Сүхбаатар	2018.01.15	1200	66	81	147
3	Баянгол	2018.01.20	2200	80	373	453
4	Сонгинохайрхан	2018.01.20	800	65	121	186
5	Баянзүрх	2018.01.21	3200	110	521	631
6	Багахангай					
7	Хан-Уул	2018.01.21	800	71	110	181
8	Налайх	2018.03.17	300	24	10	34
9	Багануур	2018.03.17	300	39	14	53
Нийт			9800	521	1295	1816

д/д	Аймаг	Уулзалт хийсэн огноо	Уулзалтад оролцсон иргэдийн тоо	Уулзалтын үеэр санал, хүсэлтээ илэрхийлсэн иргэд		
				Биечлэн илэрхийлсэн /микрофон дээр хэлсэн/	Бичгээр илэрхийлсэн	Нийт
1	Хэнтий	2018.01.24	400	48	22	70
2	Дорнод	2018.01.25	900	36	20	56
3	Сүхбаатар	2018.01.26	500	47	25	72
4	Дорноговь	2018.01.27	550	44	15	59
5	Говьсүмбэр	2018.01.28	400	38	15	53
6	Өмнөговь	2018.02.03	450	43	16	59
7	Дундговь	2018.02.04	400	25	22	47
8	Орхон	2018.02.09	500	39	19	58
9	Хөвсгөл	2018.02.10	300	40	12	52
10	Булган	2018.02.11	400	36	13	49
11	Дархан-Уул	2018.02.20	500	48	23	71
12	Сэлэнгэ /Зүүнхараа/	2018.02.21	900	87	51	138
13	Төв аймаг	2018.03.18	250	31	13	44
14	Архангай	2018.03.19	350	32	12	44
15	Завхан	2018.03.20	380	24	18	42

16	Говь-Алтай	2018.03.21	600	37	19	56
17	Баянхонгор	2018.03.22	600	49	60	109
18	Ховд	2018.05.05	400	31	19	50
19	Баян-Өлгий	2018.05.06	600	30	73	103
20	Увс	2018.05.07	500	35	10	45
21	Өвөрхангай /Хархорин/	2018.05.26	450	39	33	72
Нийт			9880	839	510	1349

Уулзалтын үеэр иргэдээс бичгээр ирүүлсэн захидал, өргөдөл болон санал хүсэлтийг агуулга, сэдэв, чиглэлээр нь ангилан авч үзвэл:

д/д	Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийн агуулга	Иргэдээс бичгээр ирүүлсэн санал хүсэлтийн тоо	Биечлэн илэрхийлсэн /микрофон дээр хэлсэн/	Нийт
1	Тэтгэврийн асуудлаар	282	208	490
2	Оффшор данстай холбоотой асуудлаар	156	106	262
3	УИХ-ыг тараах асуудлаар	101	160	261
4	Ажилгүйдэл, ядуурлын асуудлаар	121	132	253
5	Төрийн байгууллагуудын буруутай шийдвэр /төрийн албаны томилгоо, сонгон шалгаруулалт/ болон үйл ажиллагаатай холбоотой асуудлаар	130	85	215
6	Төрийн шагнал, одон медаль	97	80	177
7	Орон сууцны асуудлаар	120	44	164
8	Улс төрийн асуудлаар	89	61	150
9	Татварын асуудлаар	88	52	140
10	Өр, зээл, зээлийн хүү бууруулах асуудлаар	75	65	140
11	Биечлэн уулзах хүсэлт гаргасан	57	78	135
12	Утаа, агаарын бохирдлын асуудлаар	90	42	132
13	Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар	37	92	129
14	Ерөнхийлөгчийн засаглалтай болохыг дэмжсэн	57	65	122
15	Газрын асуудлаар	45	66	111
16	ОУ-ын харилцаа, зээл тусламжийн	-	92	92

	талаар			
17	Шүүхийн байгууллага, шүүхийн шийдвэр болон шүүх засаглалтай холбоотой асуудлаар	75	16	91
18	Орон нутгийн төсөв, санхүүжилтийн тухай	-	89	89
19	Орон нутгийн удирдлага, удирдах байгууллагуудын талаар гомдол, зөрчил	-	83	83
20	Эрүүл мэнд, боловсролын асуудлаар	65	16	81
21	Эмийн сан, эмийн хөнгөлөлтийн асуудлаар	-	79	79
22	Мөнгөн дэмжлэг болон тэтгэмж хүссэн асуудлаар	42	35	77
23	Шүүхийн шийдвэр хэрэгжихгүй байгаа /эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр ажил, албан тушаалаас халагдсан/ асуудлаар	42	32	74
24	Уул уурхай, лицензийн асуудлаар	-	72	72
25	Төсөл, хөтөлбөрүүдийг хөдөлгөх асуудлаар	34	32	66
26	Байгаль орчин, бохирдол, хог хаягдлын тухай	-	64	64
27	Банк, санхүүгийн асуудлаар	32	26	58
28	АТГ-тай холбогдох асуудлаар	22	36	58
29	МУ-ын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар	13	41	54
30	Хэлмэгдүүлэлт, цагаатгах болон уучлал үзүүлэх асуудлаар	26	25	51
31	Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн талаар	-	51	51
32	ҮАБ, Тусгаар тогтнолын асуудлаар	16	34	50
33	Цаазын ялыг сэргээх асуудлаар	19	29	48
34	Зөрчлийн тухай хууль	22	24	46
35	Залуучуудын идэвх, оролцооны тухай	-	46	46
36	Зам тээвэр, орон нутгийн хөгжлийн асуудлаар	-	44	44
37	Монгол цэрэг хөтөлбөр	19	18	37
38	Урлаг, спортын хөгжлийн талаар	-	35	35
39	Иргэний харьяатын асуудлаар	12	19	31

Нийт	1984	2374	4358
-------------	-------------	-------------	-------------

Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, шаардлага, шүүмжлэлийг тухайн чиглэл, асуудал бүрээр ангилан үзэж тодорхой асуудлаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд мэдээлэл хийж, Монгол Улсын Засгийн газарт болон төрийн бусад байгууллагад хүргүүлж, санал чиглэл өгч ажиллав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, шаардлагыг тусгах, дорвитой зарим арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг онцгойлон анхаарч ажиллаж байна.

2.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, “Сайн хөршүүд” олон улсын төрийн бус байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар, Сургуулийн нийгмийн ажилтнуудын нийгэмлэг хамтран Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Ерөнхийлөгчид хүргэх миний үг” аяныг зохион байгуулав.

“Ерөнхийлөгчид хүргэх миний үг” аян 2018 оны 5 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд үргэлжилж, 180 гаруй ЕБС-ийн 6-18 насны хүүхдүүдээс 10516 захидал, 1268 гар зураг ирснээс зураг, захидал нийлсэн 100 орчим шилдэг бүтээлийг олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2018 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Төрийн ордны Төрийн түүхийн музейн үзэсгэлэнгийн танхимд дэлгэн танилцуулав.

2.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн “Сонгогдсон болон томилогдсон төрийн албан тушаалтан авлига, хээл хахуулийн хэрэгт холбогдсон нь тогтоогдсон, оффшор данстай нь илэрсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нь нотлогдсон тохиолдолд хатуу хариуцлага хүлээлгэж, албан тушаалаас нь огцруулах, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болгох, энэ асуудлыг зохицуулсан олон улсын гэрээ, конвенцод нэгдэхийн төлөө бодлого, санаачилга гарган ажиллах” заалтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Авлигатай тэмцэх газрын удирдлагуудыг хүлээн авч уулзаж, сүүлийн жил гаруй хугацаанд олон нийтийн анхаарлыг татаад байгаа “60 тэрбумын” асуудлыг шалгах явц удаашралтай байгааг шүүмжилж, Монгол Улсын төрийн албан тушаалыг наймаалах сэдэв бүхий асуудлаар ярилцсан уг баримтад нухацтай хандахыг онцлон сануулж, шийдвэрлэх талаар ярилцав /2017.7.24, 2017.8.02/.

Уг асуудлаар оффшор бүсэд данстай улстөрчид, төрийн албан хаагчид, тэдний хамаарал бүхий этгээдүүдэд хандан 2017 оны долоодугаар сарын 24-ний өдрөөс хойш 49 хоногийн дотор оффшор дансаа хааж, тэнд байршуулсан мөнгөн хөрөнгөө Монголын банканд оруулж ирэхийг уриалав /2017.7.24/.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга төрийн албыг арилжаалсан “60 тэрбум”-ын нийтэд илэрхий болсон хэргийг эцэслэн шийдвэрлэх үндсэн чиг үүргийн ажлаа хангалтгүй хийж байгаа хуулийн байгууллагууд, тэдгээрийн удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэх асуудлыг хөндөн ерөнхий хяналтын сонсгол явуулах хүсэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу Монгол

Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн. Энэ нь төрийн эрхийг хууль бусаар авах буюу авахыг санаархсан бусармаг үйл ажиллагааг дахин гаргуулахгүйгээр таслан зогсоох, шударга төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн албаны мерит тогтолцоог бэхжүүлэх зэрэг онцгой ач холбогдолтой байсан. Харин Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Улсын Их Хурлын даргын зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгч хүсэлт гаргасан тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг заавал явуулах тухай хуулийн заалтыг мөн зөрчиж, сонсгол явуулахаас татгалзсан хариу өгсөн. /2017.10.09/

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр “Оффшор бүсэд байршсан мөнгөн хөрөнгийг эргүүлэн татах боломжууд” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Оффшор бүсэд байршсан мөнгөн хөрөнгийг эргүүлэн татах боломжууд” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг нээж үг хэлсэн бөгөөд тус хэлэлцүүлэгт АНУ-ын Массачусетс мужийн Зүүн хойд их сургуулийн Криминалоги ба эрүүгийн гэмт хэрэг, эрүүгийн хуулийн профессор Никос Пассас “Санхүүгийн гэмт хэргийн эсрэг Олон улсын стандартууд ба тэдгээрийн Монгол дахь нөлөө”, Швейцарын Авлига ба зохион байгуулалттай гэмт хэргийн ажиглагч байгууллагын ерөнхийлөгч, доктор Николас Жианнакопулос “Оффшор хөрөнгө ба Монголын эдийн засагт түүнийг буцаан авчрах боломжууд” сэдвээр тус тус лекц уншиж, санал солилцов /2017.11.23/.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 38 дугаар зарлигаар 2018-2019 оныг “Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил” болгон зарлаж, үүний хүрээнд Монгол Улсын Их Хурал болон Засгийн газарт дараах 3 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Үүнд:

1. Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг судлан сайжруулах, авлигыг илрүүлж илчилсэн иргэнийг урамшуулах, хамгаалах, авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэрчийг хамгаалах асуудлын хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилт, хэрэгцээ шаардлагыг үнэлэн судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг цаг алдалгүй авах;
2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлын хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэргийн гэрч, мэдээлэгчийг аюулгүй байдлын болон амьдрах нөхцөл, эдийн засгийн баталгаагаар хангах асуудлыг шийдвэрлэх;
3. Шүүх ажиллагааны аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах асуудлын хүрээнд төрийн байгууллагуудын чиг үүрэг, тогтолцоог улам боловсронгуй болгох.

2.4. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга иргэдтэй хийсэн уулзалтуудын үеэр иргэд хувийн амьдралын хүндрэл бэрхшээлээсээ илүүтэй нийгэмд шударга ёс алдагдаж, авлига, хүнд суртал гаарсныг хөндөн, энэ гажуудлыг таслан зогсоож тэмцэх үүрэгтэй төрийн байгууллага маш муу ажиллаж байгааг шүүмжилж,

Авлигатай тэмцэх газрын удирдлагуудыг солин, үйл ажиллагааг нь эрчимжүүлж, үр дүнтэй ажиллуулах санал, шаардлагуудыг ирүүлсэн.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.5 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Авлигатай тэмцэх газрын дарга болон дэд даргыг Улсын Их Хуралд санал болгохдоо иргэдийн санал хүсэлтийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан ёсны www.president.mn цахим хуудсаар явуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга иргэдийн нэр дэвшүүлсэн хүмүүсээс хуулийн шаардлагыг хангаж, хамгийн олон санал авсан Даваанямын Даваа-Очирыг Авлигатай тэмцэх газрын даргаар, Жанжаагийн Батсайханыг Авлигатай тэмцэх газрын дэд даргаар тус тус томилуулахаар Улсын Их Хуралд санал хүргүүлсэн.

2.5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухааныг дэмжих бодлого баримтална гэж заасны хүрээнд “Бага дунд боловсролын удирдлагын шинэчлэл” олон улсын чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулав. Уг олон улсын чуулганд Монгол Улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад, Бүгд Найрамдах Тува, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан-Уйгурын өөртөө засах орны багш, судлаачдын төлөөлөл оролцож бага, дунд боловсролын шинэчлэлийн талаар өөрсдийн санал, бодлоо илэрхийлэв.

2.6. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр 26 тоот захирамж гаргаж, “Монголын язгуур суртахуун, уламжлалт соёл, бусад орнуудын боловсролын гүн ухаан, үзэл баримтлалыг харьцуулан судлах, Монгол Улсын боловсролын гүн ухаан, үзэл баримтлалыг тодруулан оновчлох, асуудлын хүрээнд хэлэлцүүлэг, судалгааны ажлыг зохион байгуулан гүйцэтгэж, төрөөс хэрэгжүүлбэл зохих бодлогыг боловсруулан танилцуулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулав. Уг ажлын хэсэг боловсролын бодлогын хөгжил, хэрэгжилт, тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны аргазүйн дагуу ард иргэдийн оролцоотойгоор судалж байна.

Ажлын хэсгийн ажлын ажлын хүрээнд “Боловсрол ба хүмүүжил” сэдэвт хэлэлцүүлгийг 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, “Боловсролын чанар” хэлэлцүүлгийг 4 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Иргэний танхим”-д тус тус зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэгт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны удирдлагууд, Боловсролын хүрээлэн, багш бэлтгэдэг төрийн ба төрийн бус их дээд сургууль, боловсролын чиглэлээр ажилладаг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын болон иргэдийн төлөөлөл оролцов. Ажлын хэсэг санал дүгнэлт боловсруулж байна.

2.7. Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа хэрээс хэтэрч, байгаль орчныг сүйтгэж, орон нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх болон малчид, тариаланчдын хууль ёсны эрх ашигт ноцтой хохирол учруулж байгаа тухай иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын мөрөөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар даргын 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 45 дугаар

захирамжаар Ерөнхийлөгчийн Байгаль орчин, хот хөдөөгийн хөгжлийн бодлого, агаар бохирдлын асуудал хариуцсан зөвлөхөөр ахлуулсан БОАЖЯ, УУХҮЯ, МХЕГ, АТГ, АМГТГ, Хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөллүүд оролцсон ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2017 оны 9 дүгээр сарын 22-ноос 10 дугаар сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд:

1. Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг, Галуут зэрэг сумдын нутагт ашигт малтмалын ашиглалтын, биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийхээр үйл ажиллагаа явуулж буй 17 аж ахуй нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж шаардлагатай арга хэмжээг авч ажиллав.
2. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Өгөөмөр-Өргөө” ХХК, “Онолт мөнх” ХХК, “АУМ-Алт” ХХК, “Буд-Ундрэм” ХХК, “Баярсгоулд” ХХК-уудын үйл ажиллагаатай танилцаж холбогдох арга хэмжээг авч ажиллав.
3. Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “БНМС” ХХК, “Голден хаммер” ХХК, “Алтай голд” ХХК, “Батбродерс” ХХК-уудын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох арга хэмжээг авч газар дээр нь ажиллав.

Ажлын хэсэг иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын мөрөөр авах арга хэмжээний Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, хяналт шалгалтын үйл ажиллагааг 2018 онд үргэлжлүүлэн 21 аймагт ашигт малтмалын ашиглалтын болоод нөхөн сэргээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААН-ийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцахаар төлөвлөн ажиллаж байна.

2.8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт Иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалж, спортыг дэмжинэ ажиллана гэж заасны хүрээнд 2018 оны 5 дугаар сарын 04-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын “Иргэний танхим”-д “Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчин, иргэний эрүүл мэндийн эрхийн тухай” хэлэлцүүлгийг зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Төрийн бус байгууллага болон хуульч, эрх зүйч, эрдэмтэн судлаачид оролцсон.

“Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчин, иргэний эрүүл мэндийн эрхийн тухай” хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан саналын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд “Спортын орон тооны бус зөвлөл” байгуулахаар тогтсон. Мөн тус хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

2.9. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2020 оны 8 дугаар сард Монгол Улсад зохион байгуулахаар төлөвлөөд байгаа Олон улсын “Азийн хүүхдүүд” спортын наадмын хорооны удирдлагуудыг хүлээн авч уулзаж, тус спортын наадмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулагдан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2.10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын Үндэсний чуулган”-ыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Хүнсчидийн холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран Төрийн ордны Их Танхимд 2017 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулав.

“Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын Үндэсний чуулган”-ы хүрээнд:

1. “Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, гахай, тахианы мах үйлдвэрлэгчдийн тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам”;
2. “Сүү, ус, ундаа, тос үйлдвэрлэгчдийн тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам”
3. “Төмс, хүнсний ногоо, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам”;
4. “Монгол хүний эрүүл мэнд – Хүнсний аюулгүй байдал” сэдэвт дөрвөн салбар хуралдаан; хэлэлцүүлэг Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд болсон.

Чуулганаас Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангахад хууль эрх зүйн орчин, дотоодын үйлдвэрлэлийг сайжруулах, хүнсний хяналт, хэрэглэгчдийн хүнсний тухай мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар үндсэн дөрвөн чиглэл бүхий зөвлөмжийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн хүрээнд 2018 онд улсын төсвийн хөрөнгөөр Зам-Үүд, Алтанбулагийн чөлөөт бүсэд импортын хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэх хилийн боомт дахь хүнсний хяналтын лабораторийг байгуулахаар болсон.

2.11. Монгол Улсын Ерөнхийлөгч аймаг, нийслэлийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр иргэдээс тэтгэврийн асуудлаар ирүүлсэн санал, хүсэлтийг судлан үзэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 09 дүгээр захирамжаар Үндэсний тэтгэврийн тогтолцоог шинэчлэх асуудлыг судлан тодорхойлж, Засгийн газарт чиглэл өгөх санал, төслийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Ажлын хэсэг иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу төрийн байгууллага, холбоод, Олон Улсын суурин төлөөлөгчдийн газруудтай уулзалт ярилцлага, судалгаа шинжилгээ хийн ажилласан бөгөөд “Үндэсний тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн талаар” зарлигийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн. Тус чиглэлд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн даатгалын сангийн засаглал, эрх зүйн орчныг болон тэтгэврийн даатгалын хамралт, тэтгэврийн даатгалын сангийн чадавх, тэтгэвэр тооцоолох аргачлалыг сайжруулах талаар тусгагдсан болно.

2.12. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга иргэдтэй хийсэн уулзалтуудын үеэр иргэдээс хүүхдийн мөнгийг тэгш хүртээмжтэй олгох, иргэдэд уул уурхайн ногдол ашиг олгуулах, ажлын байрыг бий болгож ядуурлыг арилгах зэрэг санал, шаардлага ирүүлсний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах эрхийнхээ

хүрээнд хүүхэд бүрд “Хүүхдийн мөнгө олгох” хуулийн төслийг санаачлан УИХ-д өргөн барьсан.

2.13. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга аймаг, нийслэлийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр бага насны хүүхдийг хүчирхийлэн бэлгийн дур хүслээ зүй бусаар хангаж, амь насыг нь хөнөөсөн, амь нас, эрүүл мэндэд нь ноцтойгоор заналхийлж хохироосон, хүүхдийн насан туршийн амьдралд арилшгүй толбо, нөхөж баршгүй хор уршиг, хохирол учруулсан гэмт хэргүүд олноор гарах болсонд иргэд жигшин дургүйцэж, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах, жигшүүрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цаазаар авах хүнд ял оногдуулж, хатуу цээрлүүлж байх санал, шаардлагыг иргэдээс тасралтгүй ирүүлсэн.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас дараах арга хэмжээнүүдийг шат дараатайгаар зохион байгуулж ажиллав. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилгаар “Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах төрийн бодлогын хэрэгжилтийг сайжруулах, олон нийтийн оролцоо, хяналт” сэдвээр хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан. Хэлэлцүүлгээс гаргасан санал, зөвлөмжийн хүрээнд Засгийн газрын шийдвэрээр Цагдаагийн ерөнхий газрын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт хийж, “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасаг” байгуулагдан ажиллаж байна.
- Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах бүрэн эрхийнхээ хүрээнд “бага насны хүүхдийг санаатайгаар алах, эсхүл хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн хүнд цаазаар авах ял оногдуулж болох” тухай нэмэлт, өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулахаар хуулийн төсөл санаачилж, хуулийн төсөлд иргэдийн саналыг авах зорилгоор төслийн танилцуулга, үзэл баримтлалыг www.president.mn цахим хаягт байршуулсан.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Хүүхэд хамгаалал, өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав.

2.14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах дэлхийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдвээр Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг холбогдох газруудад уламжлан үүрэг, чиглэл өгч, бодлого үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна /2017.11.30/.

2.15. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн “Монгол үндэстний үе улиран уламжилж ирсэн нүүдлийн мал аж ахуйн сонгодог соёлыг тээгч малчин түмэн, эх орныхоо газрын шимээр хүн амынхаа хүнсний хэрэгцээг хангагч тариаланчдынхаа нийгмийн асуудалд онцгой анхаарч, тэдний

эдийн засгийн өсөлтөд чиглэсэн санал санаачилгыг төрийн бодлогод тусган ажиллах” зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч арьс шир боловсруулах болон арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төлөөлөлтэй уулзаж, үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан.

“Монгол Шевро”, “Хос аз” үйлдвэрийн удирдлагууд болоод ажилтнууд арьсны чанар муу болоод хиймэл арьсан бүтээгдэхүүнтэй өрсөлдөх боломж хязгаарлагдмал байгаа талаар Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцууллаа. Бод малын түүхий эдийн чанар мөн л муу бөгөөд сүүлийн дамжлагаар гарч ирсэн арьс нь чанаргүй байгаа юм байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийг дагалдан явсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг бог болоод бод малын арьсны гэмтлийг бууруулахын тулд малын өвчлөлийг бууруулахаар тавдугаар сарын эхнээс энэ асуудалд онцгой анхаарч, малчдын анхаарлыг хандуулах боломжтой талаар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад танилцуулсан юм.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан “Мал аж ахуйн тогтвортой хөгжил-2018” малчдын улсын зөвлөгөөнд оролцож “...хөдөө аж ахуйг анхаарлаасаа гаргаагүй. Бодлого дутагдсан маш том салбар мөн. Энэ салбар өндийж байж уул уурхайгаас илүү хөдөө аж ахуйн салбар илүү олон хүний амьдралд хэрэгтэй гэдгийг ойлгодог болох ёстой. Та бүхэн ч мөн сонгогдсон гишүүддээ асуудал дэвшүүлээрэй” гээд Монголын ноос ноолуур болон оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ руу гаалийн татваргүй оруулж байсан 1990-ээд оны сайн туршлагыг сэргээх талаар санал тавьж байгаагаа мэдэгдсэн юм. Мөн Бэлчээрийг усалгаатай болгох, говийг усжуулах санал, төслүүдэд санхүүжилт босгохоор сонирхогч талуудтай хэлэлцсээр байгаа гэх мэт малчдадаа нэмэр тус болохоор зүйлс хийхээр чармайж байгаа ба малчдын зүгээс эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх, ажил хэрэг болгох Засгийн газрыг шахаж, шаардаж өгөхийг хүссэн юм. Аливаа төсөл, ажил хэрэг оролцогч бүх талын идэвх, санаачилгаар л урагшлахаас бус дан ганц төр, засагт найдвал бүтэхгүй тул тал талаасаа л санаж, сарвайж бодитой ажил хийж байж л малын ашиг шимээс олох орлого эрс өснө гэдгийг цохон тэмдэглээд Мал аж ахуйн тогтвортой хөгжил сэдэвт малчдын улсын зөвлөгөөний үйл ажиллагаанд амжилт хүсэж, санал бодлоо уралдуулан салбарынхаа хөгжилд дорвитой өөрчлөлт авч ирэх шийдлүүд гаргахыг хүссэн юм.

3. Эдийн засгаа сэргээж, аж үйлдвэрийг хөгжүүлсэн эх оронч Ерөнхийлөгч байна.

3.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт Эдийн засгийнхаа бүтцийг шинэчлэн олон тулгууртай болгох бодлого хэрэгжүүлж, инновацад суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгч Монгол Улсын иргэн бүр байгалийн баялгийг тэгш, шударгаар эзэмших, хувь хүртэх, үр өгөөжийг нь ашиглах боломжийг хуулиар хамгаалах бодлого, үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжиж ажиллана гэж заасан зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, “Хөгжил ардчилал” ТББ болон Конрад-Аденауэр сан хамтран “Баялгийн засаглал” хэлэлцүүлгийг 2018

оны 02 дугаар сарын 26-ны өдөр Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулсан.

3.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга У.Бямбасүрэн, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ганхуяг тэргүүтэй тус компанийн удирдлагуудыг 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авч уулзсан.

Уулзалтаар Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааны 14.6 хувь нь иргэдэд байгаа тул энэ хувийг өсгөж, 100 хувь болгох хуулийн төслийг удахгүй УИХ-д өргөн барих бөгөөд энэ хуулийн төсөл батлагдвал 3000 төгрөгийн ногдол ашиг бус 300 000 төгрөгийн ногдол ашиг хуваарилах, мөн бүх иргэддээ хувьцааг 100 хувь өгөхөөр УИХ шийдсэн тохиолдолд сонгуулийн үед захиас даалгавар болгож өгсөн өр тэглэх тухай асуудал ч гэхэд хэдхэн жилийн ногдол ашгаар шийдэгдэх боломжтой болж, Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх Үндсэн хуулийн 6.1 дэх заалт хэрэгжих нөхцөл бүрдэхийг цохон тэмдэглэсэн юм.

3.3. Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдтэй хийсэн уулзалтын үеэр иргэдээс Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан цэргийн албан хаагчдыг үндэсний томоохон бүтээн байгуулалтад оролцуулах замаар мэргэшсэн ажиллах хүчний нөөц бий болгох зорилтыг дэмжиж, төрийн тусгай албан хаагч болон хугацаат цэргийн албан хаагчид улс эх орны бүтээн байгуулалт ашиглах, барилгын цэргийн ангийг дахин сэргээх зэрэг саналуудыг ирүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Цэргийн албан хаагчдыг үндэсний томоохон бүтээн байгуулалтад оролцуулах замаар мэргэшсэн ажиллах хүчний нөөц бий болгох, залуучууд цэргийн алба хаах хугацаандаа орлого олж, хуримтлалтай болох “Нэг үндэстэн-Нэг цэрэг” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр зарлигаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, зэвсэгт техникийг улсын хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам батлагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 02 дугаар сард генералуудтай хийсэн уулзалтын үеэр “Бүтээн байгуулалт-Монгол цэрэг” хөтөлбөрийг танилцуулж, санал солилцсон.

ийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

3.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 255 дугаар зарлигаар “Үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал-Төрийн гэрэгэ” шагналыг бий болгож, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд шинэ жишиг болж, олон улсын стандартыг ханган, улс орныхоо хөгжлийн илэрхийлэл, өрсөлдөх чадварын нэрийн хуудас болон үнэлэгдсэн дэд бүтэц, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал ба бизнесийн шинэ чиглэлийн онцгой бүтээн байгуулалтад олгож байна.

Өнөө жил “Үндэсний бүтээн байгуулалтын дээд шагнал - Төрийн гэрэгэ” 2017 оны шагналыг Агаар, орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллыг дахин төлөвлөх ажлын хүрээнд иргэдийн орон сууцны хэрэгцээг хямд төсөр зардлаар хангах эдийн засгийн үр өгөөж бүхий, барилгын салбарын орчин үеийн шаардлагыг иж бүрэн хангасан, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, улирал харгалзахгүйгээр ажиллах боломжтой, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн; нийгэм, эдийн засаг, барилгын салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахуйц бүтээн байгуулалт - “Эрэл” ХХК-ийн “Байшин үйлдвэрлэх комбинат-1”; Монголын дээд боловсролын төдийгүй номын сангийн салбарын нүүр царай болохуйц, дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээ, барилга байгууламж бүхий эрдэм шинжилгээ, сургалт судалгааны түшиц номын сан-мэдээллийн төв болгон; хөрөнгө оруулалтын дийлэнхийг их сургууль өөрийн нөөц бололцоогоор шийдэж, зураг төсөл, барилга байгууламж, засал шийдэл зэрэг бүхий л ажлыг үндэсний аж ахуйн нэгжүүд гүйцэтгэн бүтээн байгуулсан, монголчуудын оюун санааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй Монгол Улсын Их Сургуулийн Номын сангийн бүтээн байгуулалт; Орон нутгийн иргэдийн амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, аймгийн төвийн сумын хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор орон сууцжуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд улсын хэмжээнд жишиг болохуйц бүтээн байгуулалт өрнүүлж буй Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумын Шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтад тус тус хүртээсэн.

4. Экологийн тэнцвэрийг хангаж, газар нутгаа хамгаалсан эх оронч ерөнхийлөгч байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Монгол орныхоо байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглах, байгальд учруулж буй хүний болон аж үйлдвэрийн хор хөнөөл, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах замаар экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, унаган байгалиа хойч үедээ өвлүүлэн үлдээхэд онцгой анхаарч ажиллах” зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа.

4.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ой хээрийн түймэр газар авсанд анхаарлаа хандуулж, өөрийн биеэр Төв аймгийн Батсүмбэр сумын ойн түймэртэй бүс нутагт ажиллан, Ерөнхийлөгчийн ажлаа түймрийн голомтоос эхлүүлэв. Түүнчлэн ой хээрийн түймэр унтраахад Зэвсэгт хүчний анги, салбаруудаас татан оролцуулах тухай зарлиг гаргав /2017.7.16-18/.

Уг зарлигт Сэлэнгэ, Төв, Хэнтий, Булган аймгийн нутаг дэвсгэрийг хамран гарсан ой хээрийн түймэр унтраах, учирсан хор уршгийг арилгах арга хэмжээнд Зэвсэгт хүчний анги, салбаруудаас Монгол Улсын Засгийн газрын саналын дагуу хүч хэрэгсэл татан оролцуулахыг Зэвсэгт хүчний Жанжин штаб /дэслэгч генерал Д.Даваа/-т зөвшөөрч, Ой хээрийн түймэр унтраахад оролцох зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн удирдлагаар хангаж, аюулгүйн арга хэмжээг чанд мөрдөж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штаб /дэслэгч генерал Д.Даваа/-т үүрэг болгосон юм.

4.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний чуулган”-ыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Байгаль орчин, аялал, жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран Төрийн ордны Их танхимд 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан.

“Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний чуулган”-ы хүрээнд:

1. “Гэр хороололд үүсэж буй агаарын бохирдол, түүнийг шийдвэрлэх арга зам”;
2. “Тээврийн хэрэгсэл, орчны бохирдлоос үүсэж буй агаарын бохирдол, түүнийг шийдвэрлэх арга зам”;
3. “Төвлөрлийг сааруулах, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт 3 салбар хуралдаан, хэлэлцүүлэг болсон.

Чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Х.Баттулга, Монгол Улсын Ерөнхий Сайд, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний Хорооны дарга У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн Ахлах зөвлөх, Цаг уур орчны шинжилгээний газар, Авто тээврийн үндэсний төв, ХБНГУ-ын Байгаль орчны агентлагийн мэргэжилтэн, Монгол Улсын Их сургуулийн эрдэмтэд, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургууль, “Утааны эсрэг ээж, аавууд” ТББ, Майдар төсөл, Эко клуб ТББ болон эрдэмтэн судлаачид, иргэдийн төлөөллөөс бүрдсэн 1600 хүн оролцож, бодлого шийдлийг хэлэлцэж, 4 үндсэн чиглэл бүхий зөвлөмжийг гаргасан юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өргөтгөсөн байдлаар хуралдаж “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” 03/03 дугаар зөвлөмжийг гаргасан бөгөөд Монгол Улсын Их Хуралд “Агаар, ус, хөрсний бохирдол гамшгийн түвшинд хүрсэн гэж үзэж онцгой байдлын горимоор ажиллах, гамшгийн бүс тогтоож хориглох зүйлсийг гаргах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн сэргээх, дахин төлөвлөх үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, төрийн захиргааны байгууллагууд, их дээд сургуулиуд, тэдгээрийг дагасан дэд бүтцийн байгууламжуудыг нүүлгэн шилжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох, иргэд, байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг хангах” зэрэг асуудлуудын хүрээнд эрх зүйн орчин бүрдүүлэхийг зөвлөсний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга агаарын бохирдолтой

“Онц байдал” зарлан тэмцэх асуудлаар УИХ-ын дарга М.Энхболдод санал хүргүүлсэн.

5. Экспортын шинэ эринийг эхлүүлсэн, эрх тэгш гадаад харилцааг хөгжүүлэгч Ерөнхийлөгч байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Эдийн засгийн хувьд бие даасан, хараат бус, эрчимтэй хөгжих таатай орчныг бүрдүүлж, бүс нутаг, олон улсын түвшинд харилцан ашигтай, үр өгөөжтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн, Монгол Улсад үйлдвэрлэсэн мэдлэг, үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүнийг экспортлох зах зээлийг тасралтгүй тэлэх...” зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллав.

5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын эдийн засгийн III чуулга уулзалтад оролцов. Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад оролцох үеэрээ ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин, Япон Улсын Ерөнхий сайд Ш.Абэ болон бусад улс орнуудын төрийн тэргүүнтэй уулзаж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд хамтран ажиллах талаар санал солилцсон.

5.2. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Женнифер Зимдал Галтыг бүрэн эрхийн хугацаа нь өндөрлөж, эх орондоо буцаж байгаатай нь холбогдуулан 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авч уулзахдаа Монголд үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-д татваргүй экспортлох талаар санал дэвшүүлж байсан тухайгаа дурдаад уг асуудлыг АНУ-ын Конгрессоор дэмжүүлж өгөхийг хүсэж буйгаа илэрхийлсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Оёдлын салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, гарц, шийдэл” зөвлөгөөнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ дахь эмэгтэй гишүүдийн бүлэг, ХХААХҮЯ, Үндэсний хөгжлийн газар, Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл, үйлдвэрлэгчид хамтран 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Оёдлын салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, гарц, шийдэл” зөвлөгөөнийг нээж хэлсэн үгэндээ “...Монголын ардчиллыг дэмжих зорилгоор Монголд үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл хувцсыг АНУ-д татваргүй оруулах, экспортыг дэмжих зорилгоор бидэнд АНУ 1992 онд тодорхой квот өгч байсан. Харамсалтай нь бид тэр боломжийг ашиглаж чадаагүй. Бид өөрсдөө 1992 онд мөнгөтэй байгаагүй. Оёдлын машин худалдаж аваад, хэдэн ажилчин аваад заал түрээслээд ажиллах боломжтой хүн байгаагүй учраас Хятад, Хонконг, Макаогийн эзэд ирээд энэ квотыг ашигласан. Тэд ажлын хямд хүч ашиглаж өөрсдийн бүтээгдэхүүнээ Монгол Улсын нэрээр АНУ руу гаргаж байсан. Загас барих энэ аргыг бид тэгэхэд ашиглаж чадалгүй алдаа гаргасан. Би Монгол Улсын Ерөнхийлөгч болоод АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Женнифер Галттай уулзаж энэ байдлыг хэлж дахин санал тавьсан. Монгол Улс АНУ-тай дипломат харилцаа тогтоогоод 30 жил болж байна. Энэ 30 жилийн ойд зориулаад Монгол Улсад өмнөх квотыг сэргээж өгөөч гэсэн санал тавьсан. Конгресст нөлөөлж болох хэсэг хүнийг 12

дугаар сарын эхээр Монголд ирүүлэхээр уриад байна” гээд чуулганы дараа төлөөлөгчид, ажлын хэсэгтэй энэ талаар мэдээлэл хийхээ илэрхийлсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Оёдлын салбарын хөгжлийн өнөөгийн түвшин, гарц, шийдэл” зөвлөгөөнд оролцогчдын санал, шийдэл болон Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын хүрээнд 2017 оны 12 дугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампд Монголд үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл хувцсыг одоогийн байгаа худалдааны системийн хүрээнд АНУ-ын зах зээлд татваргүйгээр экспортлох боломжийг олгохыг хүссэн захидал илгээсэн юм. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампаас хоёр орны эдийн засгийн харилцаа бололцоогоо бүрэн ашиглаж чадахгүй байгааг дурдаад худалдаа, хөрөнгө оруулалт, шударга, харилцан ашигтай хэлбэрээр өргөжүүлэх арга замыг эрэлхийлэхдээ таатай байх ба АНУ-ын Хилийн чанад дахь хувийн хөрөнгө оруулалтын корпорац зэрэг худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллагууд Монгол Улстай ялангуяа хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүчний салбарт бизнесийн харилцааг өргөжүүлэх сонирхолтой байгааг илэрхийлсэн хариу захидлыг ирүүлсэн.

АНУ-ын Конгрессын нэр бүхий гишүүд Гуравдагч хөршийн худалдааны хуулийг хэлэлцүүлэхээр Конгресст өргөн барьсан. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монголын оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн АНУ-ын зах зээлд татваргүй экспортлогдох, Монгол Улс-АНУ-ын хоорондох худалдаа нэмэгдэхээс гадна оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний салбарт монгол эмэгтэйчүүдийн ажлын байр олноор нэмэгдэнэ гэж үзэж байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсад үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл хувцсыг АНУ-д татваргүй экспортлох асуудлыг шинээр эхлүүлэх, гадаадад буй Монгол Улсаас хууль бусаар гарсан хөрөнгө, мөнгийг эргүүлэн авахад АНУ-ын дэмжлэгийг авах талаар тус улстай хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

5.3. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 6 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд БНХАУ-ын Дарга Ши Жиньпиний урилгаар БНХАУ-ын Чиндао хотноо болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 18 дахь удаагийн өргөтгөсөн хуралдаанд оролцож үг хэлсэн.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 18 дахь удаагийн өргөтгөсөн хуралдааны үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ, БНХАУ, Беларусь, Киргиз, Казахстан болон Иран улсын Ерөнхийлөгч, Энэтхэг улсын Ерөнхий сайдтай хоёр талын уулзалтуудыг хийсэн. Эдгээр уулзалтуудаас хамгийн чухал асуудал нь БНХАУ-ОХУ-Монгол Улсын гурван талт уулзалт байлаа. Тус уулзалтын үеэр олон жил яригдсан эдийн засгийн коридор буюу хоёр хөршийн худалдааны эргэлтийг улсаараа дамжин өнгөрөөх бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин анх удаагаа энэ төслийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Мөн “Монгол-Оросын санаачилга-2018” ажил хэргийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад айлчилсан Эрхүү мужийн Амбан захирагч С.Г.Левченкогийн танилцуулсан эдийн засгийн коридор байгуулах төслийг мөн ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинд гардуулсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуулиар олгосон төрийн байгуулал, улс орны удирдлагын талаарх, үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаарх, гадаад харилцааны талаарх бүрэн эрх болон бусад хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлж, Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хангахын төлөө ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР